



ШҮҮХИЙН СУРГАЛТ,  
СУДАЛГАА,  
МЭДЭЭЛЛИЙН ХҮРЭЭЛЭН

ШҮҮХИЙН УРЬДЧИЛСАН  
ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН ТАЛААРХ  
ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

СУДАЛГААНЫ САН: ИХ/00/2022/11/29

ШҮҮХИЙН СУДАЛГААНЫ ТӨВ  
2022.11.18



**ТОВЬЁГ**

|  |    |
|--|----|
| ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ .....                     | 2  |
| УДИРТГАЛ.....                                      | 3  |
| НЭГ. ШҮҮХИЙН УРЬДЧИЛСАН ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН ТАЛААР ..... | 4  |
| ЕРӨНХИЙ ОЙЛГОЛТ .....                              | 4  |
| ХОЁР. ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА.....                    | 9  |
| ДҮГНЭЛТ .....                                      | 27 |
| ЭХ СУРВАЛЖ.....                                    | 29 |



### ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

|                |  |
|----------------|--|
| <b>БНСУ</b>    | Бүгд Найрамдах Солонгос Улс                          |
| <b>БНХАУ</b>   | Бүгд Найрамдах Хятад Ард Улс                         |
| <b>ЗХШХШТХ</b> | Захиргааны Хэрэг Шүүхэд Хянан Шийдвэрлэх тухай Хууль |
| <b>ИБУИНХУ</b> | Их Британи Умард Ирландын Нэгдсэн Хант Улс           |
| <b>ИХШХШТХ</b> | Иргэний Хэрэг Шүүхэд Хянан Шийдвэрлэх тухай Хууль    |
| <b>ИПХ</b>     | Иргэний Процессын хууль                              |
| <b>ОХУ</b>     | Оросын Холбооны Улс                                  |
| <b>ХБНГУ</b>   | Холбооны Бүгд Найрамдах Герман Улс                   |
| <b>ШССМХ</b>   | Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэн       |
| <b>ЭХШХШТХ</b> | Эрүүгийн Хэрэг Шүүхэд Хянан Шийдвэрлэх тухай Хууль   |



## УДИРТГАЛ

### Судлах зүйл

Судалгааны ажлын хүрээнд “иргэний хэрэг маргааныг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны хүрээнд шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг”-ийн талаарх хуульд зохицуулах хэрэгцээ шаардлага, гадаад улсын хуулийн ижил, төстэй зохицуулалтын зорилго, хамрах хүрээ, түүний ач холбогдол, үр нөлөө зэргийг харьцуулсан судлахад оршино.

### Судалгааны хамрах хүрээ

Судлах зүйлийн хүрээнд харьцуулсан судалгаа хийх улсаар ХБНГУ, Япон Улс, БНСУ, БНХАУ, ОХУ-ыг сонгон авч, судалгаанд хамруулсан болно.

### Судалгааны арга зүй

Судалгааг хийж хийж гүйцэтгэхдээ харьцуулан судлах, задлан шинжилж, нэгтгэн дүгнэх арга зүйг ашиглав.

### Судалгааны бүтэц

Тус судалгаа нь Иргэний хэргийн шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн ерөнхий ойлголт, Харьцуулсан судалгаа, Дүгнэлт, Эх сурвалж гэсэн хэсгээс бүрдэнэ.



## НЭГ. ШҮҮХИЙН УРЬДЧИЛСАН ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН ТАЛААР ЕРӨНХИЙ ОЙЛГОЛТ

Монгол Улсын ИХШХШТХ-ийн 76 дугаар зүйлийн 76.1.1-т “хэрэг хянан шийдвэрлэхэд ач холбогдолтой нотлох баримт хангалттай бүрдсэн гэж шүүгч үзсэн, эсхүл энэ хуулийн 71.1-д заасан хугацаа дууссан, түүнчлэн шаардлагатай гэж үзсэн тохиолдолд шүүгч уг хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх тухай захирамж гаргаж, шүүх хуралдаан хэзээ, хаана болохыг товлох” талаар заажээ.

Уг зохицуулалтын хүрээнд хэргийн талаар шүүгчтэй хэлэлцэх боломж шүүх хуралдаан дээр байх бөгөөд шүүх хуралдаан хойшлоогүй тохиолдолд шүүхийн шийдвэр гарна.

Энэ нь талуудад хангалттай мэтгэлцэх боломж олгодоггүй, шүүгчид хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг урьдчилан чиглүүлэх боломжгүй байдалд хүргэдэг учраас шүүхийн шийдвэр “хууль ёсны” бөгөөд “үндэслэл бүхий байх” шаардлагыг хангаагүй байх үр дагаврыг бий болгож байна гэж үзэж ИХШХШТХ-ийн шинэчилсэн найруулгын төсөлд “шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг”-тэй холбоотой зохицуулалт тусгах талаар Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн яамны сайдын баталсан “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын үзэл баримтлалын төсөл”-д дурджээ.

Монгол Улсын ИХШХШТХ нь 2002 онд батлагдсан ба өнөөг хүртэл хүчин төгөлдөр үйлчилж байгаа билээ. Тус хуульд “шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг”-тэй холбоотой зохицуулалт тусгагдаагүй боловч цаг хугацааны хувьд сүүлд батлагдсан хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль болох ЗХШХШТХ, ЭХХШТХ-ийн зохицуулалтад “шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг”-ийн тухай зохицуулалт тусгагдсан байна.

Дурдсан салбар эрх зүйн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд тусгагдсан зохицуулалтыг доорх хүснэгтээр харуулбал:

| ЗХШХШТХ  | ЭХХШТХ  |
|--|---|
| <b>ШҮҮХИЙН УРЬДЧИЛСАН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ</b>  | <b>ГУЧИН ГУРАВДУГААР БҮЛЭГ ЯЛЛАГДАГЧИЙГ ШҮҮХЭД ШИЛЖҮҮЛЭХ, ШҮҮХ ХУРАЛДААНЫ БЭЛТГЭЛ ХАНГАХ АЖИЛЛАГАА</b>  |
| <b>70 дугаар зүйл. Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг явуулах журам</b>  | <b>33.1 дүгээр зүйл. Яллагдагчийг шүүхэд шилжүүлэх асуудлыг шийдвэрлэх</b>  |
| 70.1. Шүүгч дараахь хүсэлтийг хүлээн авснаас хойш долоо хоногийн дотор <b>урьдчилсан хэлэлцүүлгээр хянан хэлэлцэнэ:</b>                        | 4. Талууд шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг явуулах <b>хүсэлт гаргаагүй бол шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийг явуулахгүй байж болно.</b>  |
| 70.1.1. нотлох баримт хасуулах;  | 5. Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийг энэ хуульд заасан үндэслэлээр хаалттай явуулж болно.  |
| 70.1.2. захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэх;  | 6. Шүүхийн <b>урьдчилсан хэлэлцүүлгээр яллах дүгнэлтэд заасан гэмт хэргийн хүрээнд талуудын гаргасан хүсэлт, гомдлоор, эсхүл шүүгч өөрийн санаачилгаар дараахь асуудлыг хянан хэлэлцэж шийдвэр гаргана:</b> |
| 70.1.3. хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэх;  | 6.1. өмгөөлүүлэх эрхээ хэрэгжүүлэхтэй холбоотой хүсэлт;   |
| 70.1.4. хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүгчээс урьдчилсан хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлэх шаардлагатай гэж үзсэн бусад асуудал. | 6.2. хохирогчийн хууль ёсны төлөөлөгчийг томилох, өөрчлөх талаархи санал, хүсэлт;   |
| 70.2. Шүүх хуралдааныг товлон зарлахад <b>урьдчилсан хэлэлцүүлэг хийнэ.</b>  | 6.3. эрүүгийн хэргийг түдгэлзүүлэх, эсхүл энэ хуулийн 1.5 дугаар зүйлийн 1.2, 1.3, 1.4, 1.5-д заасан нөхцөл байдал бий болсонтой холбоотой хүсэлт;  |
| 70.3. Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн товыг гурваас доошгүй хоногийн өмнө хэргийн оролцогчид, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгчид мэдэгдэнэ.    | 6.4. прокурорын яллах дүгнэлтэд гарсан үг, үсэг, тоо, тооцооны зэрэг техникийн шинжтэй алдааг засуулах хүсэлт;  |
|  | 6.5. яллагдагч гэмт хэргийн улмаас учирсан хохирол, нөхөн төлбөрийг төлөх тухай хүсэлт;   |



|   |  |
|---|--|
| <p>70.4.Хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч урьдчилсан хэлэлцүүлэгт оролцохгүй тухай шүүхэд мэдэгдэх бөгөөд <b>мэдэгдээгүй нь урьдчилсан хэлэлцүүлэг явуулахад саад болохгүй.</b></p> <p>70.5.Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг <b>мэтгэлцэх зарчмаар явагдах</b> бөгөөд хэргийн оролцогчид гаргасан хүсэлт, татгалзлын үндэслэлээ нотолно.</p> <p>70.6.Хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч <b>хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хүрэлцэн ирээгүй нь шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийг хойшлуулах үндэслэл болохгүй.</b></p> <p>70.7.Энэ хуулийн 70.1.2-т заасан хүсэлтийг шийдвэрлэх хугацааг хэргийн оролцогчдыг татан оролцуулснаас хойш тооцно.</p> <p>70.8.Шаардлагатай бол энэ хуулийн 70.1-д заасан хугацааг нэг удаа 10 хүртэл хоногоор шүүгч сунгаж болно.</p> <p>70.9.<b>Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийг шүүгч дангаар удирдан явуулж</b>, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга энэ хуулийн 88 дугаар зүйлд заасны дагуу үйлдсэн тэмдэглэлтэй хэргийн оролцогч танилцаж болно.</p> <p>70.10.<b>Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгээр нэхэмжлэлийн шаардлагатай холбоотой асуудлыг хэлэлцэхгүй.</b></p> | <p>6.6.хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлүүлэх хүсэлт;</p> <p>6.7.яллагдагч, хохирогч нар сайн дураараа эвлэрэх тухай хүсэлт;</p> <p>6.8.яллах дүгнэлт албан ёсоор гардуулаагүй тухай гомдол;</p> <p>6.9.шүүх хуралдааны товын талаархи санал, хүсэлт;</p> <p>6.10.шүүх хуралдаанд дуудах хохирогч, гэрч, шинжээч, шинжлэн судлуулах нотлох баримтын талаархи прокурор, оролцогчийн санал, хүсэлт;</p> <p>6.11.шүүх хуралдааныг хаалттай явуулах хүсэлт;</p> <p>6.12.таслан сэргийлэх арга хэмжээтэй холбоотой санал, хүсэлт;</p> <p>6.13.нотлох баримт цуглуулж, бэхжүүлэх талаар энэ хуульд заасан журам зөрчигдсөн талаар гаргасан гомдол;</p> <p>6.14.хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад оролцогчийн эрхийг зөрчсөн, хууль бусаар хязгаарласан тухай гомдол;</p> <p>6.15.мөрдөн шалгах ажиллагаа нэмж хийлгэх хүсэлт;</p> <p>6.16.хөрөнгө хураан авах ажиллагаатай холбоотой санал, хүсэлт;</p> <p>6.17.эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан тогтоол албан ёсоор танилцуулаагүй болон уг тогтоол ойлгомжгүй тухай гомдол.</p> <p>8.Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэгт оролцох хүсэлт гаргасан тохиолдолд хохирогч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчийг оролцуулж болно. <b>Хохирогч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч ирээгүй нь шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийг хойшлуулах үндэслэл болохгүй.</b></p> <p>9.Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн товыг прокурор, өмгөөлөгчийн саналыг харгалзан шүүх тогтоож, <b>урьдчилсан хэлэлцүүлэг явуулахаас 3-аас доошгүй хоногийн өмнө оролцогчид мэдэгдэнэ.</b></p> <p>10.<b>Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийг шүүгч дангаар удирдан явуулж</b>, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга энэ хуулийн 11.7, 11.8 дугаар зүйлд заасны дагуу тэмдэглэл үйлдэж, прокурор, оролцогчид танилцуулна.</p> <p><b>11.Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгээр яллагдагчийн гэм буруу, эрүүгийн хариуцлага хүлээлгэхтэй холбоотой асуудлыг хэлэлцэхгүй.</b></p> <p><b>12.Шүүхийн шатнаас урьдчилсан хэлэлцүүлэг рүү хэрэг буцаахгүй.</b></p> |
|---|--|

Дээрхээс үзвэл, хэдийгээр эрүүгийн эрх зүй болон захиргааны эрх зүйн салбар нь диспозитив зарчим хэрэгждэг иргэний эрх зүйн салбараас эрс ялгаатай хэдий ч ЗХШХШТХ, ЭХХШТХ-д тусгагдсан “шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг” нь шүүхийн үйл ажиллагаа, шүүх хуралдааныг тасралтгүй явуулах зарчимтай уялдан хэрэгждэг онцлог ажиллагаа төдийгүй иргэний Үндсэн хуулиар хамгаалагдсан “шүүхэд хандах”, “шударга шүүхээр шүүлгэх”, “шүүхийн өмнө эрх тэгш байх” зарчимд нийцэх, хэргийн оролцогч, яллагдагч нарын эрхийг хангах зорилготой зохицуулалт гэж дүгнэж болохуйц байна. Түүнчлэн энэхүү зохицуулалтын зорилго нь эрх зүйн мэдлэг дутмаг иргэдэд нэхэмжлэлийн шаардлагаа зөв тодорхойлох, талууд харилцан тэгш эрхтэйгээр шүүх хуралдааны үйл ажиллагааг эхлүүлэхэд ихээхэн эергээр нөлөөлөхүйц зохицуулалт гэж үзлээ.



Иймд Монгол Улсын эрх зүйн тогтолцоотой төстэй байхаар гадаадын бусад улсын ИПХ-д тусгагдсан “шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг”-ийн зохицуулалт, түүний үүсэл хөгжлийг судалж үзсэн. Үүнд:

## 1. ЕВРОПЫН ИРГЭНИЙ ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНЫ ЗАГВАР<sup>1</sup>

Европын иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бүтэц нь эрх зүйн түүхэн хөгжил, соёлын ялгаатай байдлаас шалтгаалан харьцангуй өөр өөр байдаг. Эдгээр нь иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилго, иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ерөнхий зарчим, үзэл баримтлалын харилцан ялгаатай байдлаас үүдэлтэй. Тухайлбал, шүүгчийн гүйцэтгэх зохих үүргийн талаарх ойлголт нь иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бүтцэд нөлөөлдөг.<sup>2</sup>

Шүүгч маргаантай байгаа гол асуудлуудыг тодруулж, тодорхойлоход идэвхтэй оролцдог тогтолцоо нь эцсийн хэлэлцүүлэг болохоос өмнө шүүгч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд идэвхтэй оролцох загварыг бий болгохыг шаарддаг байна.<sup>3</sup>

XIX зууны болон XX зууны эхэн үед Европт үндсэн 4 төрлийн иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны загвар байжээ. Үүнд:

1. Иргэнлэг эрх зүйн (civil law);
2. Нийтлэг эрх зүйн (common law);
3. Формаль коммунист;
4. Скандинавын орны ангилал.

Эдгээр ангилал тус бүр нь өөрийн гэсэн онцлог хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бүтэцтэй.

Европын иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны нийтлэг эрх зүйн бүтэц нь дараах 3 үе шатаас бүрдэнэ.



<sup>1</sup> Anna Nylund, The Structure of Civil proceedings – Convergence through the main hearing model?, 2018, p-15.

<sup>2</sup> Мөн тэнд. Эшлэл 1. 14 дэх тал.

<sup>3</sup> Мөн тэнд. Эшлэл 2.



Эдгээр үе шатанд шүүгчийн оролцоо “идэвхгүй” төлөвтэй байх ба хэргийг хянан шийдвэрлэх процесс ажиллагаа талуудын удирдлагад, мэтгэлцээний үндсэн дээр хэрэгжинэ гэж ойлгож болох юм. Энэхүү загвар нь аман хэлэлцүүлэг, мэтгэлцээнд суурилдаг тул нэхэмжлэл гаргахдаа түүний шаардлагыг тодорхой зааж, асуудал тус бүрийг нэг бүрчлэн нарийвчлан тодруулсан байх ёстой.

Шүүхийн өмнөх шатанд шүүх хуралдаанд бэлтгэж шүүхийн (захиргааны) ажилтан эсхүл шүүгч өөрөө нотлох баримтыг олж авах, цуглуулах, танилцуулах, үнэлэх, түдгэлзүүлэхтэй холбоотой үйл ажиллагааг явуулна. ИБУИНХУ-ын хувьд хэргийн менежер гэх хүн нэхэмжлэлийн гол асуудлыг тодорхой болгон хялбарчилж, асуудлыг тодорхойлоход туслах үйл ажиллагааг хэрэгжүүлдэг байна. Шүүх хурал бол талууд нотлох баримтаа шүүгчид (эсвэл тангарагтны шүүгчид) танилцуулж, иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шүүгчийн үүрэг бол зөвхөн шүүх хуралдааны явцад гаргасан материалд тулгуурлан хэргийг шийдвэрлэх явдал юм.

Сүүлийн 10 жилийн хугацаанд иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд урьдчилсан хэлэлцүүлэг (сонсгол)-ийг явуулах талаар түгээмэл хандлага дэлгэрч байна. Энэхүү загвар нь Франц Клейний санаанаас үүсэлтэй ба ХБНГУ, ИБУИНХУ-ын хуулийн шинэчлэлээс эхлэлтэй. Түүнчлэн ALI/UNCITRAL-ийн Үндэстэн Дамнасан Иргэний Хэрэг Хянан Шийдвэрлэх Ажиллагааны Зарчмууд (PTCP) гэсэн баримт бичигт урьдчилсан хэлэлцүүлэг (сонсгол)-ийн талаар тусгагдаж эхлэх болжээ. Үүний дараагаар Скандинавын орнууд зэрэг бусад хэд хэдэн улс иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаандаа урьдчилсан хэлэлцүүлэг (сонсгол)-ийн зохицуулалтыг тусгах болсон байна.<sup>4</sup>

## 2. УРЬДЧИЛСАН ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН ЗАГВАРУУД<sup>5</sup>

### Скандинавын орны загвар:

Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны (Бүгд Найрамдах Финланд Улс)-аас бусад Скандинавын орны бүтэц нь ХБНГУ, Австрийн Холбооны Улсын иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны шинэчлэлд суурилсан гурван үе шаттай загварыг авч хэрэгжүүлсэн.

**Нэхэмжлэл гаргах үе шат нь бичгийн эсхүл аман бэлтгэлийн үе шатаар үргэлжлэх бөгөөд үндсэн үүрэг нь сонсгох ажиллагааг хэрэгжүүлэх явдал байв.** Гэсэн хэдий ч шүүх хурлын өмнөх бэлтгэл үе шат нь хөгжсөн хэвээр байсан ба Шведийн Хант Улсад шүүх хуралдааныг дийлэнх тохиолдолд зөвхөн бичгэн хэлбэрт үндэслэн явуулдаг байсан бол Дани, Норвеги зэрэг улсад зөвхөн товч тойм мэдээлэл, тайлбарыг солилцох үйл явцаас бүрддэг байв.

### Коммунист загвар:

Энэ загвар нь социалист үзэл санаатай холилдсон иргэний эрх зүйн уламжлал дээр суурилдаг ба **нэхэмжлэл гаргах үе шат нь хэд хэдэн сонсголоос бүрдэх нэг сонсголын ажиллагааны үргэлжлэх хугацаа 1 цагаас ихгүй байхаар зохицуулдаг** байжээ. Энэхүү процедурын загварыг “холимог шүүх хурал” гэж нэрлэсэн байдаг. Учир нь нотлох баримт авах, цуглуулах хэргийн талаар талууд мэтгэлцэх нь холилдсон байдаг. Шүүгч хэргийг

<sup>4</sup> Anna Nylund, The Structure of Civil proceedings – Convergence through the main hearing model?, 2018, p-14.

<sup>5</sup> Anna Nylund, The Structure of Civil proceedings – Convergence through the main hearing model?, 2018, p-16.



шийдвэрлэхэд бэлэн болсон гэж дүгнэж, сонсголын ажиллагааг дуусгах хүртэл шинэ үндэслэл, нотлох баримтыг оруулж болно.

Дээр дурдсан загваруудад 1970-аад оноос өөрчлөлт орж эхэлжээ. ХБНГУ-ын системд хамгийн сүүлд 2001 онд шинэчлэл хийгдсэн байна. **Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шинэчлэл хийж хялбарчлахын гол зорилго нь зардлыг хэмнэж хугацааг богиносгох, нэг шүүгчээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг нэмэгдүүлэх, урьдчилсан хэлэлцүүлэг (сонсгол)-ын тоог цөөлөх, бичгэн болон аман хэлэлцүүлгийн тэнцвэрийг сайжруулах** билээ. Дараа дараагийн боловсронгуй болж хөгжсөн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны шинэчлэлд “шүүгч идэвхтэй оролцож” аман болон бичгийн хуралдааны тэнцвэрийг нэмэгдүүлэх нь чухал болсон.

**Шүүгч хэлэлцүүлгийн явцад хөндлөнгөөс оролцож цаг алдалгүй талуудаас асуулт асуух замаар маргааны зүйл болон нэхэмжлэлийн талаар тодруулснаар цаг хэмнэх төдийгүй шүүгч гол асуудлуудыг тодорхойлж, талуудын зүгээс шаардлагагүй, урт, төвөгтэй мэдээлэл өгөхөөс зайлсхийх давуу тал үүснэ.** Цаашилбал, “идэвхтэй шүүгч” нь хэргийн үйл баримтыг тодруулж, хуралдааныг зохион байгуулж, ерөнхий болон аман хэлэлцүүлгийг төлөвлөх боломжтой.

#### **Ромын загвар<sup>6</sup>:**

Ромын загвар нь мөн гурван үе шаттай хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай байсан. Эхний үе шатанд нэхэмжлэл гаргах, дараагийн үе шат нь нотлох баримт бүрдүүлэх үйл ажиллагаа хамаарна. **Нотлох баримт бүрдүүлэх үе шат нь хэд хэдэн богино сонсголоос бүрдэж байсан бөгөөд энэ үеэр талууд нотлох баримтыг хянан шалгах буюу зааварлагч шүүгчид танилцуулдаг.**

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг үргэлжлүүлэх хангалттай нотлох баримт байгаа эсэхийг шалгасны дараа шүүгч хэргийг шийдвэрлэхээр шүүх бүрэлдэхүүнд шилжүүлнэ.

**Ромын загварын хувьд нотлох баримт бүрдүүлэх үе шат дууссаны дараа нэхэмжлэлийн шаардлага, нэхэмжлэлийн үндэслэлийн тодорхой болсон байх ёстой.**

#### **ХБНГУ-ын загвар<sup>7</sup>:**

Урьдчилсан хэлэлцүүлэг (сонсгол)-ийн загвар нь ХБНГУ-ын иргэний эрх зүйн системд олон жилийн түүхэн уламжлалтай. Гэвч практикт түүний орчин үеийн хэлбэр нь олон шинэчлэлийн замаар аажмаар гарч ирсэн. Уламжлалын дагуу шүүгч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг зохион байгуулж, удирдан явуулахад (Prozessleitung) чухал үүрэг гүйцэтгэдэг байна.

Шүүгч нь урьдчилсан хэлэлцүүлэг (сонсгол)-ийн огноог тогтоож, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хугацааг сунгаж эсхүл богиносгон, хэргийг нэгтгэж эсхүл тусгаарлах эрхтэй. **Урьдчилан таамаглах, талуудад адил тэгш хандах нь Германы хууль тогтоомжид чухал ач холбогдолтой боловч бэлтгэл ажиллагаа нь уян хатан байдаг бөгөөд шүүгч бичгээр болон аман бэлтгэлийн аль нэгийг сонгох эрхтэй.** Аман хэлэлцүүлгийн үед ч бичмэл материалыг давталгүйгээр иш татах боломжтой байдаг.

**Үүний гол зорилго нь хэргийг аль болох хугацааг нь тулгалгүйгээр шийдвэрлэх, хэргийг үндсэн хуралдаанд бэлтгэхэд иж бүрэн бэлтгэл хангах явдал.**

<sup>6</sup> Мөн тэнд, Эшлэл 5. 17 дахь тал.

<sup>7</sup> Мөн тэнд, Эшлэл 5. 18 дахь тал.



Талууд өөрсдийгөө төлөөлж байгаа эсхүл хэргийг хэсэгчлэн болон бүхэлд нь хэрэгсэхгүй болгосон тохиолдолд бэлтгэл сонсголыг зарлах ба энэ шатыг алгасаж үл болно. **Шүүхийн зүгээс талуудыг нэхэмжлэлийн шаардлагаа ихэсгэх эсхүл багасгаж өөрчлөх, нэмэлт мэдээлэл, нотлох баримт гаргаж өгөхийг зөвлөх, гэрчийг дуудаж асуух, шинжээч томилох, эрх бүхий байгууллагаас мэдээлэл гаргуулан авах талаар чиглэмж өгөх эрхтэй байдаг нь ХБНГУ-ын шүүгч нар хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд “тодруулга хийх” үүргийг өргөнөөр хэрэгжүүлэх үүрэгтэй байдагтай холбоотой.** Уг үүрэг нь талуудад маргаантай асуудлуудыг тодорхойлоход туслах, талуудын эрх тэгш байдлыг хангахад оршино. Шүүгчийн тодруулга хийх үүрэг нь талуудын үзэл баримтлал, маргааны зүйлээр хязгаарлагдах бус тухайн маргааныг шийдвэрлэхэд тодруулах шаардлагатай бүх зүйлс хамаарна. Жишээлбэл: “Шүүх нь талуудтай хэргийн үйл баримтын талаар ярилцахаас гадна, талуудын харилцааг тодруулж, хэргийн бодит байдал болон түүний эрх зүйн үр дагаврын талаар ярилцаж, асуулт асуух үүрэгтэй.” байна.

Шүүх болон шүүгчийн энэхүү үүрэг нь шаардлагатай тохиолдолд өргөжих боловч талуудын гаргасан нэхэмжлэл, тайлбар, танилцуулсан баримтаар хязгаарлагдана.

Шүүх талуудын гаргасан баримтууд, нэн ялангуяа бүх чухал баримтыг баталгаажуулсан байх ёстой ба ингээгүй тохиолдолд талуудад мэдэгдэж нэмэлт баримт цуглуулах талаар мэдээлэл өгөх, холбогдох нотлох баримтыг гаргуулах, хүсэлтийг зохих ёсоор гаргуулах, талуудад зөвлөмж, санал өгөх (Hinweispflicht) ёстой.

Шүүхээс хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бүх шатанд маргааныг бүхэлд нь буюу хэсэгчлэн эвийн журмаар шийдвэрлэхийг дэмжих үүрэгтэй ба шүүх хуралдааны бэлтгэл үе шат нь үндсэн сонсголоор төгсдөг.

Судалгааны ажлын хүрээнд сонгон авсан гадаад улсын ИПХ-д шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн талаар хэрхэн зохицуулсан талаар доорх байдлаар дэлгэрэнгүй үзүүлэв.

## ХОЁР. ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

### 1. ХБНГУ-ЫН ИПХ-Д ТУСГАГДСАН “ШҮҮХИЙН УРЬДЧИЛСАН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ (СОНСГОЛ)” БУЮУ “FRÜHER ERSTER TERMIN”<sup>8</sup>-ИЙН ТАЛААР

ХБНГУ-ын шүүхийн процесс ажиллагаа нь доорх дарааллын дагуу явагдаж эхэлдэг:

- Нэхэмжлэл гаргах;
- Хариуцагчид мэдэгдэх;
- Дагалдах ажиллагаа (үүнд: “урьдчилсан хэлэлцүүлэг буюу сонсгол”-оос өмнө талууд тайлбараа харилцан солилцох, шүүхээс “урьдчилсан хэлэлцүүлэг буюу сонсгол” явуулах, нотлох баримтыг цахимаар гаргаж өгөх<sup>9</sup> г.м хамаарна).

<sup>8</sup> Англи хэлээс “Advance first hearing”-ийг орчуулбал “Эхний сонсгол” болно. ХБНГУ-ын ИПХ-ийн англи хэл дээрх орчуулгад тусгагдсанаар энэхүү нэр томъёог “урьдчилсан хэлэлцүүлэг”, “үндсэн сонсгол” эсхүл “аман хэлэлцүүлэг” гэх нэр томъёогоор илэрхийлж байсан болно.

<sup>9</sup> Нотлох баримтыг цахим хэлбэрээр өгөх боломжтой. Эдгээр нотлох баримтад түүний товч мэдээлэл, тэдгээрийн хавсралт, талууд болон гуравдагч этгээдийн мэдүүлгийг багтааж болно. Энэ нь Цахим гарын үсгийн тухай хуулийн (Signaturgesetz) дагуу баталгаажсан цахим гарын үсэг шаарддаг. **Шүүх хуралдааныг танхимд биечлэн явуулах ёстой боловч урьдчилсан хэлэлцүүлэг (сонсгох ажиллагаа эсхүл аман хэлэлцүүлэг гэх), шинжээчийн үзлэг, талууд, гэрчүүдийг амаар асууж нотлох баримт бүрдүүлэх ажиллагааг зайнаас явуулж, процесс ажиллагааг буюу хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг үргэлжлүүлэн явуулж болно.** Шүүхээс бүрэн эрхийнхээ хүрээнд талуудын зүгээс гаргасан шинжээч томилох буюу шинжилгээ хийлгэх тухай хүсэлтийг өөрийн үзэмжээрээ шийдвэрлэх эрхтэй. Тодруулбал, виртуал (цахим) шүүх хурал, шинжилгээ нь цаг хугацаа хэмнэж, улмаар талуудаас гаргах зардлыг хэмнэж байгааг шүүх анхаарч



**ХБНГУ-ын ИПХ-д заасан урьдчилсан хэлэлцүүлэг (сонсгол)-ийн ажиллагааны хүрээнд талууд нотлох баримт цуглуулах, бүрдүүлсэн нотлох баримтыг тоймлон танилцуулах ажиллагаа хийгддэг гэж үздэг.**<sup>10</sup> Нотлох баримтын зөвшөөрөгдсөн эх сурвалж нь бичмэл нотлох баримт, шүүхээс хийсэн үзлэг, шинжилгээ, шинжээчийн дүгнэлт, гэрчийн мэдүүлэг, хамаарах бол хязгаарлагдмал хүрээнд нотлох баримтын эх сурвалжид талуудын байр суурь, мэдүүлэг хамаарч болно. Дээрх үйл ажиллагааны төгсгөлд шүүгч нь маргааныг хянан шийдвэрлэх шүүх хуралдааны огноог тогтоох бол зарим тохиолдолд шийдвэр гарган процессын ажиллагааг үргэлжлүүлэхээр шийдвэрлэдэг байна.<sup>11</sup>

Түүнчлэн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны нэг хэсэг буюу шүүх хурал нь нэг цул, тасралтгүй үйл ажиллагаа биш, харин шүүх нь тухайн нөхцөл байдлаас шалтгаалж хэд хэдэн хуралдааны үеэр нотлох баримт цуглуулж, үнэлдэгтэй холбоотой олон шатлалт ажиллагаа билээ.<sup>12</sup>

ХБНГУ-ын ИПХ-д заасан урьдчилсан хэлэлцүүлэг (сонсгол)-ийн зохицуулалтын үндэс нь "Stuttgart Model,"<sup>13</sup> -оос эхлэлтэй.<sup>14</sup> Энэхүү Штутгарын загвар нь 1976 онд батлагдаж 1977 оноос хэрэгжиж байгаа төдийгүй "зөвшөөрөгдсөн нөхцөл байдлын

---

үзэх юм. **ХБНГУ-ын хуульд гэрчийг сонсож, бусад нотлох баримтуудыг бүрдүүлэн авч болох нэг удаагийн урьдчилсан хэлэлцүүлэг (сонсгол ажиллагаа эсхүл аман хэлэлцүүлэг гэх) хийхээр заасан байдаг. Гэсэн хэдий ч бодит байдал дээр энэхүү ажиллагаа нь том эсвэл нарийн төвөгтэй тохиолдолд хэд хэдэн удаа хойшилж болно. Иймд талууд болон шүүх хэд хэдэн удаа хуралдаж, хэлэлцүүлэг хийх боломжтой.** Шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь ихэвчлэн шүүхийн шүүхээс санал болгосон эвлэрлийн нөхцөлөөр эсхүл талуудын хоорондын эвлэрлээр төгсдөг. Бусад тохиолдолд шүүхийн шийдвэр гарч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дуусгавар болно. (Litigation and Enforcement in Germany: Overview), [https://uk.practicallaw.thomsonreuters.com/1-502-0728?transitionType=Default&contextData=\(sc.Default\)&firstPage=true#co\\_anchor\\_a778522](https://uk.practicallaw.thomsonreuters.com/1-502-0728?transitionType=Default&contextData=(sc.Default)&firstPage=true#co_anchor_a778522) (Сүүлд үзсэн: 2022.10.24).

<sup>10</sup> Hengeler Mueller, In Review: Court Procedure in Germany, <https://www.lexology.com/library/detail.aspx?g=58fc4314-c3e1-46d7-847e-b9194585c5c1> (Сүүлд үзсэн: 2022.10.26).

<sup>11</sup> Мөн тэнд. Эшлэл 10.

<sup>12</sup> Мөн тэнд. Эшлэл 10.

<sup>13</sup> **Энэхүү загварын үндсэн агуулга нь иргэний хэргийн процесс ажиллагаа буюу иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үе шатын тоог бууруулах, процесс ажиллагааны үе шатуудыг танах замаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хурдасгах тухай юм.** ХБНГУ-ын ИПХ-д тусгагдсан 3 зарчим (шүүх хуралдааныг амаар явуулах, шүүх хуралдааныг шуурхай явуулах, шүүх нэгдмэл байх) нь бодит байдал дээр практикт бүрэн хэрэгждэггүй тул энэхүү Штутгарын загвар бий болж үүсэж хөгжжээ. Үүний үр дүнд амаар болон бичгээр шүүх хуралдааны процесс ажиллагааг явуулж үр дүн ч эергээр гарах болсон байна. Энэ загвар нь талууд, тэдгээрийн өмгөөлөгч төлөөлөгч нар тогтоосон эсхүл сунгаж болох цаг хугацаанд бичгээр гаргасан (гомдол, хариу, тайлбар) зэргээс эхэлнэ гэдэг. **Шүүхээс талуудын бүрдүүлж өгсөн нотлох баримтыг нэгтгэн, шүүгч нь танхимдаа энэ талаар мэдээлэл хүргүүлж, урьдчилсан хэлэлцүүлэг (сонсгол)-ийн өдрийг товлон, гэрчийг асууж, шинжээчийг томилдог.** Шүүх хурал нь талуудын байр суурийг бүрэн сонссоны үндсэнд эхэлж шүүхийн шийдвэр, дүгнэлт гарснаар дуусгавар болдог. Хэрэв дуусгавар болоогүй тохиолдолд дахин нотлох баримт судлах үе шат хэрэгжих ба хоёр дахь хэлэлцүүлгийн шат хэрэгжиж шийдвэр, дүгнэлт гаргана. Шүүгч болон өмгөөлөгч нараас судалгаа авахад хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хурдасгаж байгаа энэхүү загварт сэтгэлд хангалуун байгаагаар илэрхийлсэн байна. **Дээрх загвар нь урьдчилсан хэлэлцүүлэг (сонсгол)-ийн тоог бууруулж, хугацааг хэмнэж, өмгөөлөгчийн хөдөлмөр, давж заалдах процессыг хөнгөвчилсөн давуу талтай.** Bender, STUTTGART (WEST GERMANY) MODEL (FROM ACCESS TO JUSTICE, VOL 2, 1978, BY M CAPPELLETTI AND J WEISER SEE NCJ-61157), 1978, <https://www.ojp.gov/ncjrs/virtual-library/abstracts/stuttgart-west-germany-model-access-justice-vol-2-1978-m> (Сүүлд үзсэн: 2022.10.27).

<sup>14</sup> John H. Langbeint, The German Advantage in Civil Procedure (The University of Chicago Law Review), 1985, p 824. [https://openyls.law.yale.edu/bitstream/handle/20.500.13051/4901/German\\_Advantage\\_in\\_Civil\\_Procedure\\_The.pdf;jsessionid=2407D6651C3A25695C5B500118990133?sequence=2](https://openyls.law.yale.edu/bitstream/handle/20.500.13051/4901/German_Advantage_in_Civil_Procedure_The.pdf;jsessionid=2407D6651C3A25695C5B500118990133?sequence=2) (Сүүлд үзсэн: 2022.10.26).



тохиолдолд шүүх нэг удаагийн шүүх хурлаар хэргийг шийдвэрлэхийг дэмжих” гэсэн агуулгатай зохицуулалт байсан нь хожим өөрчлөгдөж “нэг удаагийн хурлаар хэргийг иж бүрэн бэлтгэж шийдвэрлэх ёстой” гэсэн агуулгатай болжээ.


ХБНГУ нь өөрөө иргэнлэг эрх зүйн тогтолцооны нэг хэсгийг бүрдүүлэгч буюу эх газрын эрх зүйн тогтолцооны томоохон төлөөлөгч улс болохын хувьд иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь үндсэн 3 хэсгээс бүрдэнэ. Тэдгээр нь 1/нэхэмжлэл гаргах, 2/нотлох баримт цуглуулах, 3/шийдвэр гаргах гэсэн үе шат болно. Одоо хүчин төгөлдөр үйлчилж ХБНГУ-ын ИПХ-д тусгагдсан зохицуулалтыг доорх байдлаар үзүүлбэл:

| №  | Хуулийн зүйл, заалтын орчуулга   |
|----|--|
| 1. | <p><b>272 дугаар зүйл. Процедурын хэлбэрийг тодорхойлох</b></p> <p>(1) Хуульд зааснаар эрх зүйн маргааныг (<b>үндсэн сонсгол</b>) иж бүрэн бэлтгэсэн аман мэтгэлцээний шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэж, дуусгавар болгоно.</p> <p>(2) Даргалагч шүүгч <b>эхний сонсголыг</b> аман хэлэлцүүлгийн (§275) хэлбэрээр эсхүл бичгээр явуулах урьдчилсан ажиллагаа (§276)-ны үндсэн дээр явуулах товыг гаргана.</p> <p>(3) Эвлэрүүлэх сонсгол болон аман хэлэлцүүлгийг аль болох боломжит богино хугацаанд зохион байгуулна.</p> <p>(4) Орон байрны халдашгүй байдалтай холбоотой маргааныг түргэвчилсэн журмаар явуулна.</p>  |
| 2. | <p><b>273 дугаар зүйл. Хэлэлцүүлэгт бэлтгэх шат</b></p> <p>(1) Шүүх шаардлагатай бэлтгэл арга хэмжээг цаг тухайд нь эхлүүлнэ.</p> <p>(2) Шүүх хуралдааны Даргалагч шүүгчээс эсхүл шүүх бүрэлдэхүүнээс шилжүүлсэн хэргийг хянан хэлэлцэж буй шүүгч нар <b>хэлэлцүүлэгт (сонсголд)</b> бэлтгэх замаар, тухайлбал дараах эрхийг хэрэгжүүлж үйл ажиллагаа явуулж болно:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Бичгээр өгсөн мэдүүлэгтээ өөрчлөлт оруулах, нэмэлт мэдээлэл, нотлох баримт өгөхийг талуудад чиглүүлэх, ялангуяа тодруулга шаардлагатай зарим зүйлийн талаар тайлбар өгөх эцсийн хугацааг тогтоох;</li> <li>2. Төрийн байгууллага, төрийн эрх бүхий албан тушаалтнаас бүртгэл, албан ёсны мэдээлэл өгөхийг хүсэх;</li> <li>3. Шүүх хуралдаанд талуудыг биечлэн оролцохыг даалгах;</li> <li>4. Шүүх хуралдаанд оролцуулах хүсэлт гаргасан гэрч, шинжээчийг дуудах, энэ талаар хуулийн 378 дугаар зүйлийн дагуу захирамж гаргах;</li> <li>5. энэ хуулийн 142, 144 дүгээр зүйлд заасны дагуу захирамж гаргах.</li> </ol> <p>...</p>  |
| 3. | <p><b>274 дүгээр зүйл. Талуудыг дуудан ирүүлэх</b></p> <p>(1) Аман хэлэлцүүлгийн тов гармагц, шүүхийн хариуцсан ажилтан талуудад мэдэгдэх үүрэгтэй.</p> <p>(2) Хэрэв шүүх <b>эхний сонсголыг</b> явуулахаар болсон бол нэхэмжлэлийг зарлан дуудах хуудастай хамт хариуцагчид хүргүүлнэ.</p> <p>(3) Талуудыг дуудан ирүүлэхэд Нэхэмжлэлийг хүргүүлсэн болон сонсголын огноо товлогдсоноос хойш шүүх хуралдааны огнооноос хойш дор хаяж хоёр (2) долоо хоног өнгөрсөн байх ёстой. Нотлох баримтыг хилийг чанадаас бүрдүүлэх тохиолдолд Даргалагч шүүгч талуудыг дуудан ирүүлэх хугацаа болон <b>сонсголын</b> товыг хэрхэхийг шийдвэрлэх эрхтэй.</p>   |
| 4. | <p><b>275 дугаар зүйл. Эхний сонсгол</b></p> <p>(1) <b>Эхний сонсголын</b> ажиллагаанд бэлдэхийн тулд Даргалагч шүүгч буюу түүнээс томилогдсон шүүгч хариуцагчид бичгээр гомдолд хариу өгөх буюу хариу тайлбар гаргах хугацааг тогтоож болно. Түүнчлэн шүүхээс шүүгдэгчид өмгөөлөгч авах эрхтэй талаар чиглэмж өгч, өмгөөлөгч авах талаар хүсэлтээ бичгээр гаргах, энэхүү үйл ажиллагааг аливаа хэлбэрээр хойшлуулахгүй байхад анхаарна.</p> <p>(2) Хэрэв <b>эхний сонсголын</b> хүрээнд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг эцэслэн шийдвэрлэж, дуусгавар болгохгүй бол шүүгчээс <b>үндсэн сонсголд</b> аман хэлбэрээр мэтгэлцэх бэлтгэлийг хангах шаардлагатай бүх захирамжийг гаргана.</p> <p>(3) <b>Эхний сонсголын</b> үе шатанд, хариуцагч гомдолд хараахан хариу өгөөгүй эсвэл хангалттай хариу өгөөгүй бөгөөд энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу түүнд хариу өгөх хугацааг хараахан тогтоогоогүй бол шүүх гомдолд бичгээр хариу өгөх хугацааг тогтооно.</p> <p>(4) <b>Эхний сонсголын</b> үе шатанд, нэхэмжлэгч хариуцагчийн тайлбарыг хүлээн авсны дараа, шүүх нэхэмжлэгчийн хувьд хариуцагчийн тайлбарын талаар өөрийн байр сууриа бичгээр илэрхийлэх эцсийн хугацааг тогтоож болно. Даргалагч шүүгч энэ хугацааг шүүх хуралдаанаас гадуур тогтоож болно.</p> |



|   |
|---|
| <b>5. 276 дугаар зүйл. Бичгээр явуулах урьдчилсан ажиллагаа</b><br>(1) Даргалагч шүүгч эхний сонсголын аман хэлэлцүүлгийн товгыг тогтоогоогүй тохиолдолд нэхэмжлэлийг гаргаснаас хойш 2 долоо хоногийн дотор тэрээр хариуцагчид хариу тайлбар гаргах хүсэл байгаа эсэхийг тодруулсны үндсэнд энэ талаар нэхэмжлэгчид мэдэгдэнэ. Үүний зэрэгцээ хариуцагчийн хувьд хариу тайлбараа бичгээр гаргах эцсийн хугацааг тогтооно, энэ хугацаа нь дор хаяж хоёр (2) долоо хоног байна. Хилийн чанадад байгаа нэхэмжлэлийг хүлээн авагч буюу хариуцагчийн хувьд, Даргалагч шүүгч эхний өгүүлбэрийн дагуу эцсийн хугацааг тогтоох эрхтэй. |
|---|

Тус улсын онцлог нь нэхэмжлэл гаргасны дараагаар шүүх хуралдааны бэлтгэл үе шат эхлэх ба энэ шатанд урьдчилсан хэлэлцүүлэг (сонсгол) явагддаг, цаашилбал шаардлагатай тохиолдолд, зохимжтой гэж үзвэл хэд хэдэн удаа энэхүү ажиллагаа явагддаг онцлогтой байна. Тухайн урьдчилсан хэлэлцүүлэг (сонсгол)-ийг аман болон бичгээр гэсэн хэлбэрээс сонгон явуулж болдог ба энэхүү сонсголын ажиллагаагаар иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эхний үе шат төгсдөг.



ХБНГУ-д ИПХ-д үгийн шууд утгаар орчуулбал “эхний сонсгол” буюу “first hearing”, “үндсэн сонсгол” буюу “main hearing” гэсэн ялгаатай нэр томъёо, ойлголт тусгагджээ. Гэвч “эхний сонсгол” нь үндсэн сонсголын нэг хэсэгт хамаарах ойлголт байна гэж үзлээ. Иймдээ ч эхний сонсголыг амаар явуулах бол үндсэн сонсголыг эхний сонсгол цаашид үргэлжлэх шаардлагатай эсхүл талууд тухайн шатанд эвлэрээгүй тохиолдолд явуулахаар<sup>15</sup> байна. “Эхний сонсгол”, “үндсэн сонсгол” гэсэн ойлголтууд нь иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг амаар явуулах, төвлөрсөн байх гэсэн зарчимд тулгуурлан хэрэгждэг нэхэмжлэл, нэхэмжлэлийн шаардлагыг шүүгчид болон шүүх бүрэлдэхүүнд танилцуулах, маргаантай асуудлын хууль зүйн үндэслэл болон нотлох баримтыг танилцуулах (нэлээд хэд хоног үргэлжилж ч болох) нэн чухал үе шат<sup>16</sup> юм. Үүнийг Монгол Улсын хууль тогтоомжид тусгагдсантай төстэй байдлаар ойлговол, шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийг илэрхийлэхээр байна гэж үзэж болох юм.

Монгол Улсын хууль тогтоомжид тусгагдсан “урьдчилсан хэлэлцүүлэг”-тэй агуулгын хувьд дүйх ХБНГУ-ын хуульд тусгагдсан “сонсгол”-ын үе шатанд шүүгч нь талуудад нэхэмжлэлийн зүйлээ тодруулах, маргааны зүйлийг тодорхойлоход зөвлөмж, чиглэмж өгөх, нотлох баримт бүрдүүлэх, цуглуулахад туслах, эрх бүхий байгууллагаас тодорхойлолт гаргуулахыг зөвлөх, талууд цуглуулсан нотлох баримтыг товчоор танилцуулах боломж олгох, гэрчийг асуух, шинжээч томилох, хариуцагчийн зүгээс хариу тайлбар гаргах хугацааг тогтоох, энэ талаар нэхэмжлэгчид мэдэгдэх зэрэг шүүх хуралдааны өмнөх шатанд хийгдэх үйл ажиллагааг хэрэгжүүлдэг.

## 2. ЯПОН УЛСЫН ИПХ-Д ТУСГАГДСАН “ШҮҮХИЙН УРЬДЧИЛСАН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ”-ИЙН ТАЛААР

### А. Маргааны зүйлийг тогтоох ажиллагаа (争点整理手続)

<sup>15</sup> Габлерын бизнесийн толь бичиг, <https://wirtschaftslexikon.gabler.de/definition/frueher-erster-termin-33307> (Сүүлд үзсэн: 2022.11.01).

<sup>16</sup> Anna Nylund, The Structure of Civil proceedings – Convergence through the main hearing model?, 2018, p-17.



Япон Улсад хуучин Иргэний процессын тухай хууль хэрэгжиж байх үед, маргааны зүйл болон нотлох баримтыг тодорхой болгохгүйгээр анхан шатны шүүх хуралдаан явагдах нь түгээмэл байсан. Улмаар, шүүх хуралдаан удаашрах, хойшлох, үр ашиггүй байх гэх мэт асуудлууд үүсэж, ихээхэн шүүмжлэлийг дагуулдаг байв<sup>17</sup>.

Энэ нөхцөл байдлыг сайжруулах үүднээс 1996 онд шинээр батлагдсан Иргэний процессын тухай хууль нь Маргааны зүйлийг тогтоох ажиллагаа (争点整理手続)-г хуульчилсан. **Маргааны зүйлийг тогтоох ажиллагаа (争点整理手続) нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аль болох эхэн үе шатанд талуудын хооронд үүссэн маргааны гол зүйлийг тодорхой болгохын сацуу чухал ач холбогдолтой нотлох баримтуудыг тодорхой болгож цэгцлэх замаар зүй зохистой, хурдан шуурхай маргааныг шийдвэрлэх бололцоог бүрдүүлсэн<sup>18</sup>.**

Маргааны зүйл гэдэг (Япо. 争点 Анг. Point at issue ) нь материаллаг эрх зүйг хэрэглэх үед ач холбогдол бүхий, талуудын хооронд маргаантай байгаа факт, үйл баримтыг хэлнэ<sup>19</sup>. Өөрөөр хэлбэл, маргааны зүйлийг тогтоох ажиллагааны гол зорилго нь маргааны зүйлийн талаарх шүүх болон талуудын нэгдмэл ойлголтыг бий болгох, нотлох шаардлагатай үйл баримтыг тодорхой болгож хумих явдал юм<sup>20</sup>.

### **В. Маргааны зүйлийг тогтоох ажиллагааны төрлүүд**

Маргааны зүйлийг тогтоох ажиллагаа нь дотроо гурван төрөлтэй. Эдгээр нь:

- 1) Бэлтгэл шүүх хуралдаан (準備的口頭弁論),
- 2) Мэтгэлцээнийг бэлтгэх ажиллагаа (弁論準備手続) ,
- 3) Бичгээр явагдах бэлтгэл ажиллагаа (書面による準備手続) болно.

Шүүх маргааны төрөл болон агуулгаас хамааран дээрх гурван маргааны зүйлийг тогтоох ажиллагааны аль нэгийг нь сонгон хэрэглэх боломжтой<sup>21</sup>. Тухайлбал, Бэлтгэл шүүх хуралдаан (準備的口頭弁論) нь нээлттэй шүүх танхимд явагдах учир, олон тооны зохигч, оролцогчтой эсхүл бодлогын шинж чанар (хүрээлэн буй орчны маргаан г.м)-тай маргаанд илүү тохирдог. Мөн маргааны зүйл, нотлох баримт хангалттай тодорхой тохиолдолд, маргааны зүйлийг тогтоох ажиллагааг явуулалгүйгээр анхан шатны шүүх хуралдааныг шууд явуулах боломжтой<sup>22</sup>.

#### **1) Бэлтгэл шүүх хуралдаан (準備的口頭弁論)**

Бэлтгэл шүүх хуралдаан гэдэг нь маргааны зүйл болон нотлох баримтыг цэгцлэх, тодорхой болгох явдлыг зорилгоо болгосон шүүх хуралдааны нэг төрөл юм. Бэлтгэл шүүх хуралдааныг явуулах эсэхийг шүүх өөрийн эрх хэмжээгээр шийдвэрлэнэ (ИПХ 164).

Бэлтгэл шүүх хуралдааныг нээлттэй шүүх хуралдааны танхимд явуулна гэж заасан байдаг боловч, маргааны зүйлийг тогтоох, нотлох баримтыг цэгцлэх үүднээс харилцан яриа өрнүүлэхэд тохиромжтой буюу дугуй ширээ (round table)-нд ихэвчлэн бэлтгэл шүүх

<sup>17</sup> 渡部美由紀他『民事訴訟法』111頁参照（日本評論社 2016年）。

<sup>18</sup> 三木浩一他『民事訴訟法』184頁参照（有斐閣 第3版 2018年）。

<sup>19</sup> 三木・前掲注（18）184頁。

<sup>20</sup> 三木・前掲注（18）184頁。

<sup>21</sup> 三木・前掲注（18）185頁参照。

<sup>22</sup> 三木・前掲注（18）185頁。



хуралдааныг явуулдаг<sup>23</sup>. Мөн маргааны зүйлийг тогтоох, нотлох баримтыг цэгцлэхэд шаардлагатай гэж үзвэл, гэрчээр асуулгах зэрэг шүүх хуралдааны үеэр явуулах боломжтой бүхий л ажиллагааг бэлтгэл шүүх хуралдааны үеэр явуулах боломжтой<sup>24</sup>.

Бэлтгэл шүүх хуралдаан дуусах үед, шүүх болон талууд хамтран нотлох ёстой үйл баримтыг дахин нягталж баталгаажуулна (ИПХ 165.1). Бэлтгэл шүүх хуралдаанд аль нэг тал ирээгүй эсхүл гаргаж өгөх ёстой тайлбарыг гаргаж өгөөгүй тохиолдолд, шүүх бэлтгэл шүүх хуралдааныг дуусгавар болгох боломжтой (ИПХ 166). Өөрөөр хэлбэл, бэлтгэл шүүх хуралдаанаар дамжуулан хэргийг сунжруулах, удаашруулах явдлаас сэргийлэх зорилготой.

## 2) Мэтгэлцээнийг бэлтгэх ажиллагаа (弁論準備手続)

Мэтгэлцээнийг бэлтгэх ажиллагаа гэдэг нь нээлттэй шүүх хуралдааны танхимд бус бэлтгэлийн өрөө, эвлэрүүлэн зуучлах өрөө зэрэгт, шүүгчийн өмсгөлгүй шүүгч болон талууд ширээг тойрон сууж, албаны бус чөлөөтэй орчинд харилцан ярилцаж, мэтгэлцэх замаар маргааны зүйл болон нотлох баримтыг тогтоох ажиллагаа юм<sup>25</sup>. Шүүгч удирдан чиглүүлэх учир чөлөөтэй, уян хатан байдлаар маргааны зүйлийг тогтоох боломжтой (ИПХ 171.1).

Талуудын хамтын ажиллагаагүйгээр мэтгэлцээнийг бэлтгэх ажиллагааг явуулах нь хүндрэлтэй тул, мэтгэлцээнийг бэлтгэх ажиллагааг явуулахын тулд шүүх талуудын санаа бодлыг сонсож, зөвшөөрлийг нь авах ёстой (ИПХ 168).

Мэтгэлцээнийг бэлтгэх ажиллагааг явуулах шүүгч тодорхой товыг зааж талуудад мэдэгдэнэ (ИПХ 93.1, 94). Шүүх хуралдааны танхимд явуулах шаардлагагүй боловч, талууд харилцан уулзалдах боломжтой орчинд хийх шаардлагатай (ИПХ 169.1) бөгөөд шүүгч шаардлагатай гэж үзвэл бусад этгээдийг оролцуулах боломжтой (ИПХ 169.2). Шүүгч маргааны зүйлийг тогтоохын тулд, шүүгчийн тодруулах эрхийг хэрэгжүүлэх (釈明権), мэтгэлцэх зарчмыг хязгаарлах, тайлбар авах зэрэг процесс ажиллагааг явуулах мөн боломжтой. Мөн, мэтгэлцээнийг бэлтгэх ажиллагааны үед шүүгч талуудын эвлэрлийг санал болгох боломжтой (ИПХ 89).

Мэтгэлцээнийг бэлтгэх ажиллагаа нь нотлох баримтыг бүрдүүлэх, шинжлэн судлах ажиллагаа биш боловч, маргааны зүйлийг тогтоох үүднээс нотлох баримтын талаар гаргасан хүсэлтийг шийдвэрлэх, судлан шинжлэх боломжтой гэж үздэг<sup>26</sup>. Үүнээс гадна, талуудын зүгээс тайлбар гаргах (ИПХ 170.1), үйл баримтын талаар тайлбар гаргах, хууль зүйн тайлбар гаргах, нотлох баримтын талаар хүсэлт гаргах, нэхэмжлэлээс татгалзах (ИПХ 261.3), эвлэрэх, нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрөх зэрэг ажиллагааг явуулах боломжтой.

Талуудын аль нэг нь анхны мэтгэлцээнийг бэлтгэх ажиллагаанд хүрэлцэн ирээгүй боловч тайлбарыг гаргаж өгсөн бол, тухайн тайлбарын агуулгад үндэслэн мэтгэлцээнийг бэлтгэх ажиллагааг явуулна. Хоёрдох удаа хүрэлцэн ирээгүй мөн тайлбарыг гаргаж өгөөгүй тохиолдолд, мэтгэлцээнийг бэлтгэх ажиллагааг дуусгавар болгож, тухайн ажиллагааг хүчингүй болгох боломжтой (ИПХ 172).

<sup>23</sup> 伊藤眞『民事訴訟法』292頁参照（有斐閣 第6版 2018年）。

<sup>24</sup> 三木・前掲注（18）186頁。

<sup>25</sup> 三木・前掲注（18）186頁参照。

<sup>26</sup> 伊藤・前掲注（23）289頁参照。



Талуудын аль аль нь хүрэлцэн ирээгүй тохиолдолд, нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгох зохицуулалтыг дүйцүүлэн хэрэглэх (ИПХ 263), шинээр тов зарлах болон мэтгэлцээнийг бэлтгэх ажиллагааг дуусгавар болгож, хүчингүйд тооцох гэсэн гурван арга замын аль тохиромжтой арга замыг шүүх сонгон хэрэглэнэ.

Маргааныг зүйлийг тогтоох зорилгод хүрсэн эсхүл хүрэх боломжгүй нь тодорхой тохиолдолд, шүүх мэтгэлцээнийг бэлтгэх ажиллагааг дуусгавар болгоно (ИПХ 170, 165, 166). Улмаар, шүүх талуудтай хамтран нотлох шаардлагатай үйл баримтыг дахин нягталж, баталгаажуулна (ИПХ 170.5, 165.1).

Талууд мэтгэлцээнийг бэлтгэх ажиллагааны үр дүнг шүүх хуралдааны үеэр шууд амаар дахин тайлбарлах шаардлагатай (ИПХ 173) бөгөөд зөвхөн өөрт ашигтай хэсгийг сонгон авч тайлбарлахыг хориглодог<sup>27</sup>. Мэтгэлцээнийг бэлтгэх ажиллагаа дуусгавар болсны дараа, нотлох баримтыг гаргаж өгсөн тохиолдолд, эсрэг талын хүсэлтээр хугацаа хожимдсон үндэслэлээ тайлбарлах шаардлагатай болдог.

### **3) Бичгээр явагдах бэлтгэл ажиллагаа (書面による準備手続)**

Бичгээр явагдах бэлтгэл ажиллагаа (書面による準備手続) гэдэг нь талууд хүрэлцэн ирэлгүйгээр, бичгийн тайлбарыг гаргаж өгөх солилцох, түүнийг дэмжихийн тулд алсын зайнаас утсаар дамжуулан маргааны зүйл болон нотлох баримтыг тогтоох цэгцлэх ажиллагаа юм<sup>28</sup>. Утсаар дамжуулан маргааны зүйлийг тогтоох нь нэн хүндрэлтэй тул бичгээр явагдах бэлтгэл ажиллагааг хэрэглэхээс аль болох зайлсхийдэг<sup>29</sup>.

#### **1. Маргааны зүйлийг тогтоох ажиллагааг дуусгавар болгох болон үр дагавар (争点整理手続の終結)**

Маргааны зүйлийг амжилттай тогтоосноор маргааны зүйлийг тогтоох ажиллагаа дуусгавар болох боловч, талууд болон шүүхийн хооронд ойлголтын зөрүү гараагүй гэдгийг баталгаажуулах ажиллагаа шаардлагатай болдог. Тухайлбал, маргааны зүйлийг тогтоох ажиллагааг дуусгавар болох үед, яг ямар үйл баримтыг нотлох шаардлагатай вэ гэдгийг талууд болон шүүх дахин нягталдаг (ИПХ 165.1, 170.5). Ялангуяа бичгээр явагдах бэлтгэл ажиллагааны тухайд тухайн ажиллагааны дараа товлогдсон шүүх хуралдааны эхэнд маргааны зүйлийг дахин нягталж үздэг.

Түүнчлэн, талууд маргааны зүйлийг тогтоох ажиллагаанд идэвхтэй оролцолгүйгээр хамтарч ажиллахаас зайлсхийсэн тохиолдолд, маргааны зүйлийг тогтоох ажиллагааны дараа гаргаж өгсөн аливаа тайлбар болон нотлох баримтыг хязгаарлахыг эрмэлздэг (攻撃防禦方法の提出制限). Тодруулбал, эсрэг талын хүсэлтээр хугацаа хожимдсон үндэслэлээ тайлбарлах шаардлагатай болдог (ИПХ 167, 174).

#### **2. Маргааны зүйлийг тогтоох ажиллагааны шүүмжлэл**

Маргааны зүйлийг тогтоох ажиллагааны хамгийн чухал төрөл нь мэтгэлцээнийг бэлтгэх ажиллагаа (弁論準備手続) бөгөөд хууль тогтоогчийн зүгээс мэтгэлцээнийг бэлтгэх ажиллагаа нь маргааны зүйлийг тогтооход үр дүнтэй байна гэсэн өндөр хүлээлтийг тавьж байв<sup>30</sup>. Тодруулбал, судлаачид болон хууль тогтоогчийн зүгээс мэтгэлцээнийг бэлтгэх

<sup>27</sup> 伊藤・前掲注 (23) 291 頁参照。

<sup>28</sup> 三木・前掲注 (18) 188 頁。

<sup>29</sup> 三木・前掲注 (18) 189 頁参照。

<sup>30</sup> Практикт нийт маргааны зүйлийг тогтоох ажиллагааны 99%-ийг мэтгэлцээнийг бэлтгэх ажиллагаа эзэлдэг.



ажиллагааны талаар “шүүгч болон талууд хамтран 30 минутаас 1 цагийн хооронд амаар, шууд, идэвхтэйгээр санаа бодлоо солилцож, мэтгэлцээн явуулах замаар маргааны зүйлийг тогтоох ажиллагаа” гэсэн нийтлэг төсөөлөлтэй байв<sup>31</sup>. Мөн мэтгэлцээнийг бэлтгэх ажиллагааг ойролцоогоор хоёроос гурван удаа, нарийн төвөгтэй маргааны тухайд ихдээ л таван удаа явуулахад хангалттай хэмээн үзэж байв<sup>32</sup>.

Гэтэл хууль хэрэгжиж эхэлснээс хойш мэтгэлцээнийг бэлтгэх ажиллагаа нь анхны хүлээлтэд хүрээгүй бөгөөд талуудын бичгийн тайлбар солилцох талбар болж хувирсан<sup>33</sup>. Өмгөөлөгчдийн дунд явуулсан судалгаанаас үзвэл, ихэнх мэтгэлцээнийг бэлтгэх ажиллагаа нь 5-аас 15 минутын хооронд дунджаар нийт 7.3-н удаа явагддаг байна<sup>34</sup>. Түүнчлэн, шүүгч болон талууд идэвхтэй, шууд маргаан мэтгэлцээн өрнүүлдэггүй буюу шүүгч талуудын бэлдэж ирсэн бичгийн тайлбараас ойлгомжгүй эргэлзээтэй зүйлсийг тодруулах ажиллагаа (釈明)-г голчлон явуулах нь түгээмэл болсон<sup>35</sup>.

Үүнтэй холбоотойгоор, мэтгэлцээнийг бэлтгэх ажиллагааг амаар, шууд, идэвхтэйгээр явуулах нь зүйтэй гэж үздэг судлаачдын зүгээс мэтгэлцээнийг бэлтгэх ажиллагаа үр дүнгээ өгөхгүй байгаа дараах хэд хэдэн шалтгааныг гаргаж тавьсан байна<sup>36</sup>.

Нэгдүгээрт, бичгийн тайлбарыг мэтгэлцээнийг бэлтгэх ажиллагааг явуулахаас өмнө, зүй зохистой байдлаар шүүхэд гаргаж өгөхгүй байгаа явдал юм. Өөрөөр хэлбэл, мэтгэлцээнийг бэлтгэх ажиллагааг амаар, шууд үр дүнтэйгээр явуулахын тулд мэтгэлцээн өрнүүлж болохуйц хангалттай мэдээллийг талуудын зүгээс гаргаж өгөх нь чухал.

Хоёрдугаарт, шүүгч эсхүл нэг талын зүгээс идэвхтэйгээр мэтгэлцээн өрнүүлэх оролдлого хийсэн ч нөгөө тал нь мэтгэлцээнээс зайлсхийж бичгийн тайлбараар хариу өгөхийг илүүд үзэх явдал юм. Энэ нь Япон Улсад “хүний нүүрэн дээр шууд маргаан өрнүүлэхээс зайлсхийдэг” соёлтой нарийн холбоотой.

Гуравдугаарт, шууд амаар маргаан мэтгэлцээн өрнүүлэхэд үйл баримтын талаар алдаатай тайлбарыг гаргах эрсдэлтэй бөгөөд үүнийг засья гэсэн ч нэгэнт шүүгч болон нөгөө тал сонсоод дотоод үнэлэмжийг бий болгох учир энэ эрсдэлээс зайлсхийх нь зүйтэй гэж үзэх үзэл юм.

Дөрөвдүгээрт, шүүгчийн зүгээс мэтгэлцээнд идэвхтэй оролцох сонирхол байдаггүй буюу өөрийн маргааны талаарх дотоод үнэлэмжээ талуудад ил тод болгодоггүй гэсэн асуудал юм.

Улмаар, судлаачид дээрх асуудлуудыг шийдвэрлэж мэтгэлцээнийг бэлтгэх ажиллагааг сайжруулах арга замуудыг дэвшүүлсэн байдаг.

**Дүгнэн үзвэл, Япон Улс хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг үр дүнтэй шуурхай болгохын тулд маргааны зүйлийг тогтоох ажиллагаа гэсэн нэрийн дор**

<sup>31</sup> 山本和彦「争点整理手続の過去、現在、未来」高田裕成他編『民事訴訟法の理論—高橋宏志先生古稀祝賀論文集』769頁、781頁参照（有斐閣 2018年）。

<sup>32</sup> 山本・前掲注（31）782頁参照。

<sup>33</sup> 山本・前掲注（31）783頁参照。

<sup>34</sup> 最高裁判所事務総局編・裁判の迅速化に係る検証に関する報告書平成29年7月25頁表17参照（2017年）。

<sup>35</sup> 山本・前掲注（31）783頁参照。

<sup>36</sup> 山本・前掲注（31）785頁以下参照。



гурван төрлийн урьдчилсан хэлэлцүүлгийн төрлийг Иргэний процессын тухай хуульд тусгаж өгсөн байна. Эдгээр урьдчилсан хэлэлцүүлгийн гол зорилго нь маргааны зүйлийг тодорхой болгож, нотлох баримтыг бүрдүүлэх явдал юм. Хамгийн түгээмэл хэрэглэгддэг бэлтгэл хэлэлцүүлэг нь онолын хувьд маргааны зүйлийг тогтоох хамгийн үр дүнтэй ажиллагаа хэдий ч Япон Улсын тогтсон практикийн улмаас хангалттай үр дүнгээ өгч чаддаггүй байна.

### 3. БНСУ-ЫН ИПХ-Д ТУСГАГДСАН “ШҮҮХИЙН УРЬДЧИЛСАН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ”-ИЙН ТАЛААР<sup>37</sup>

БНСУ-ын ИПХ нь эх газрын эрх зүйн системд суурилдаг. 1910 онд Япон улс нь БНСУ-ыг эзлэн авснаар Япон Улсын засгийн газрын тогтоолын дагуу Япон улсын хууль тогтоомж БНСУ-д үйлчилж, дэлхийн хоёр дугаар дайн дуустал хэрэгжсэн байна. Түүхээс үзвэл, Германы ИПХ-ийг хэсэгчлэн загварчилсан Япон Улсын ИПХ нь 1877 онд батлагдсан. Европын иргэний эрх зүйн тогтолцоонд суурилсан Япон Улсын ИПХ-ийг солонгос хэл рүү орчуулж, 1960 онд Иргэний процессын шинэ хууль батлагдтал Япон улсын ИПХ-ийг хэрэглэж ирсэн.

#### **Урьдчилсан хэлэлцүүлгийн талаар:**

БНСУ-ын ИХШХШТХ-д хянан үзэх баримтуудыг нарийсгаж, маргаантай асуудлуудыг урьдчилан тодорхой болгох замаар шүүх хурлыг үр ашигтай, шуурхай явуулахад дэмжлэг үзүүлэх журмыг ("бэлтгэх ажиллагаа" гэж нэрлэдэг) заасан байдаг. Шүүх хуралтай зарим талаараа төстэй ч анхан шатны шүүх хурлын дараа ч урьдчилсан хэлэлцүүлэг (бэлтгэл ажиллагаа) явагдаж болно.

Урьдчилсан хэлэлцүүлгийг зөвхөн дүүргийн шүүхийн гурван шүүгч хянан хэлэлцсэн тохиолдолд л зөвшөөрнө. Шүүх өөрийн үзэмжээр шүүх хуралдаанд хянан хэлэлцэх ба асуудлыг бүхэлд нь эсвэл зөвхөн нэг хэсэг дээр урьдчилсан хэлэлцүүлэг (бэлтгэл ажиллагаа) явуулахыг гишүүн шүүгчдийн аль нэгэнд даалгаж болно.

Шүүгч урьдчилсан хэлэлцүүлэг (бэлтгэл ажиллагаа) хуралдааны товыг тогтоож, талуудыг дуудна. Урьдчилсан хэлэлцүүлэг (бэлтгэл ажиллагаа) нь шүүх хуралдаантай төстэй явагддаг ба шүүх хуралдаанд шаардлагатай урьдчилсан хэлэлцүүлэг (бэлтгэл ажиллагаа) хангалттай явагдсан гэж хариуцсан шүүгч үзсэн тохиолдолд уг ажиллагааг дуусгана.

Мөн шүүх хуралдаанд аль нэг тал нь товлосон өдөр хүрэлцэн ирээгүй, эсхүл шүүгчийн шаардсан товч тайлбарыг ирүүлээгүй тохиолдолд хариуцагч шүүгч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг цуцалж болно. Урьдчилсан хэлэлцүүлэг дууссаны дараа шүүх хуралдаанд шинжлүүлэх нотлох баримтыг урьдчилсан хэлэлцүүлгийн дараа шууд тодорхойлж, шаардлагатай бүх зохицуулалтыг хийж, шүүх хуралд бэлтгэнэ. Урьдчилсан хэлэлцүүлэг эхлэхээс өмнө гомдолд дурдсан, эсхүл товч тайлбарт дурдсан асуудлаас бусад урьдчилсан хэлэлцүүлгийн тэмдэглэлд тусгаагүй асуудлыг танилцуулахыг хориглодог.

|     |  |
|-----|--|
| Д/Д | БНСУ-ын ИПХ-ийн урьдчилсан хэлэлцүүлгийн талаарх зохицуулалт <sup>38</sup> |
| 1.  | 258 дугаар зүйл (Нэхэмжлэл гаргах хугацааг тодорхойлох)                    |

<sup>37</sup> Tae Hee Lee, Commercial litigation in Korea, 16, 2003.

<https://www.worldservicesgroup.com/guides/Commercial%20Litigation%20in%20Korea.pdf> (Сүүлд үзсэн:2022.11.14).

<sup>38</sup> CIVIL PROCEDURE ACT, [Enforcement Date 18. Nov, 2021.] [Act No.18396, 17. Aug, 2021., Partial Amendment].



|    |  |
|----|--|
|    | <p>(1) Шүүхийн шийдвэр гаргаснаас бусад тохиолдолд даргалагч шүүх хуралдааны товыг 257 дугаар зүйлийн 1, 2-т заасны дагуу тогтооно. <b>Урьдчилсан хэлэлцүүлэг (бэлтгэх ажиллагаа) явуулах шаардлагатай тохиолдолд шүүх хуралдааны товыг гаргахгүй.</b></p> <p>(2) Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг (бэлтгэх ажиллагаа) дууссаны дараа даргалагч шүүх хуралдааны товыг нэн даруй тогтооно. [Нэмэлт өөрчлөлт оруулсан 2008.12.26]</p>  |
| 2. | <p><b>266 дугаар зүйл (Нэхэмжлэлээсээ татгалзах)</b></p> <p>(1) Шүүхийн шийдвэр эцэслэн гарах хүртэл нэхэмжлэлийг бүхэлд нь буюу хэсэгчлэн татгалзаж болно.</p> <p>(2) Нэхэмжлэлээсээ татгалзахад хариуцагч урьдчилсан хэлэлцүүлэг (бэлтгэх ажиллагаа)-т нэхэмжлэлтэй холбоотой баримт бичгийг бүрдүүлсэн эсвэл урьдчилсан хэлэлцүүлэг (бэлтгэх ажиллагаа) үеэр мэдэгдсэн үед нэхэмжлэлээс татгалзах талаар хариуцагчийн зөвшөөрлийг авснаар хүчин төгөлдөр болно.</p> <p>(3) Нэхэмжлэлээс татгалзах үндэслэлээ дараах тохиолд бичгээр гаргана: Урьдчилсан хэлэлцүүлэг (бэлтгэх ажиллагаа)-ийн үеэр хүсэлт гаргах эсвэл нэхэмжлэл гаргахдаа амаар хэлсэн бол.</p> <p>(4) Бичгээр гаргасан хүсэлтийг хүлээн авсны дараа татгалзсан хариуг нөгөө талд бичгээр өгнө.</p> <p>(5) Энэ заалтын (3)-д заасан тохиолдолд нөгөө тал нь шүүх хуралдаанд эсвэл урьдчилсан хэлэлцүүлэг (бэлтгэх ажиллагаа)-ийн үеэр ирээгүй бол тухайн өдрийн протоколын баталгаажуулсан хуулбарыг нөгөө талд хүргүүлнэ.</p> |
| 3. | <p><b>279 дугаар зүйл (Урьдчилсан хэлэлцүүлэг (бэлтгэл ажил)-ийн тухай)</b></p> <p><b>(1) Нотлох баримтыг үнэлэх, мэдүүлэг өгөх, шүүх хуралдааныг үр дүнтэй явуулахын тулд талуудын нэхэмжлэлээр урьдчилсан хэлэлцүүлэг (бэлтгэл ажил) явуулна.</b></p> <p>(2) Даргалагч шүүгч онцгой шалтгаантай бол шүүх хуралдааны товыг гаргасны дараа ч урьдчилсан хэлэлцүүлэг (бэлтгэл ажил)-ийн явуулж болно.</p>   |
| 4. | <p><b>280 дугаар зүйл (Урьдчилсан хэлэлцүүлэг (бэлтгэл ажил) явуулах)</b></p> <p><b>(1) Урьдчилсан хэлэлцүүлэг (бэлтгэл ажил)-ээр талуудад шүүх хуралдааны товч тайлбар танилцуулах болон бусад нотлох баримт бичгийг гаргаж өгөх, харилцан солилцох, эсхүл шаардлагатай нотлох баримтыг шалгах хүсэлт гаргах замаар шүүх хуралдааны явцыг хялбаршуулна.</b></p> <p>(2) Урьдчилсан хэлэлцүүлэг (бэлтгэл ажил) нь даргалагч шүүгчийн удирдлагад явагдна.</p> <p>(3) Шүүх бүрэлдэхүүнээр шийдвэрлэж буй хэргийн хувьд шүүх бүрэлдэхүүнээс даргалагч шүүгчийг, түүнд урьдчилсан хэлэлцүүлэг (бэлтгэл ажил) ажиллагааг хариуцуулж болно.</p> <p>(4) Даргалагч шүүгч шаардлагатай гэж үзвэл урьдчилсан хэлэлцүүлэг (бэлтгэл ажил) ажиллагааг өөр шүүгчтэй хамт явуулж болно.</p>  |
| 5. | <p><b>281 дүгээр зүйл (Урьдчилсан хэлэлцүүлэг (бэлтгэл ажил)-ээр нотлох баримтыг шалгах)</b></p> <p>1) 280 дугаар зүйлийн 4-т заасны дагуу урьдчилсан хэлэлцүүлэг (бэлтгэл ажил) ажиллагааг явуулж буй даргалагч даргалагч шүүгч, томилогдсон шүүгч (цаашид "даргалагч шүүгч" гэх) шаардлагатай гэж үзвэл нотлох баримт гаргуулах шийдвэр гаргаж болно.</p> <p>2) Хамтарсан хэргийн хувьд (1)-д заасан нотлох баримт гаргуулах, талуудын гаргасан зайлшгүй өөрчлөлт, эсрэг талын эсэргүүцэлд энэ хуулийн 138 дугаар зүйлийн заалтыг дагаж мөрдөнө.</p> <p>3) Даргалагч шүүгч энэ хуулийн 279 дүгээр зүйлийн 1-д заасны дагуу шаардлагатай нотлох баримтыг шалгаж болно: Гэрч, талуудын мэдүүлгийг зөвхөн 313 дугаар зүйлд заасан тохиолдолд л явуулж болно.</p>  |
| 6. | <p><b>284 дүгээр зүйл (Урьдчилсан хэлэлцүүлэг (бэлтгэл ажил)-г дуусгах)</b></p> <p>1) Даргалагч шүүгч дараах үндэслэлүүдийн аль нэгэнд нь хамаарах бол урьдчилсан хэлэлцүүлэг (бэлтгэл ажил)-г дуусгана. Үүнд:</p> <p>a. Хэргийг урьдчилсан хэлэлцүүлэг (бэлтгэл ажил)-д шилжүүлснээс хойш зургаан сар өнгөрсөн бол;</p> <p>b. Талууд 280 дугаар зүйлийн 1-д заасан хугацаанд мэдүүлгээ ирүүлээгүй, эсхүл нотлох баримтыг шинжлүүлэхээр хүсэлт гаргаагүй бол;</p> <p>c. Урьдчилсан хэлэлцүүлэг (бэлтгэл ажил)-ийн өдөр аль нэг тал ирээгүй тохиолдолд</p> <p>d. Урьдчилсан хэлэлцүүлэг (бэлтгэл ажил) дууссан тохиолдолд даргалагч шүүгч шүүх хуралдааны товыг урьдчилан тогтооно.</p>   |

Дээрхээс дүгнэн үзвэл БНСУ-ын хуульд зааснаар урьдчилсан хэлэлцүүлгээр маргааны агуулгыг буюу нэхэмжлэлийн шаардлагыг тодорхой болгож, шүүх хуралдаанд шинжлүүлэх нотлох баримтыг урьдчилсан хэлэлцүүлгийн дараа шууд тодорхойлж, шаардлагатай бүх зохицуулалтыг хийж, шүүх хуралд бэлтгэж шүүх хуралдааныг үр дүнтэй



явуулахад чиглэдэг. Мөн БНСУ-ын урьдчилсан хэлэлцүүлэг нь бэлтгэж ажиллагаатай адил байдлаар явагддаг бөгөөд талууд нотлох баримтуудаа солилцох, нотлох баримтыг үнэлэх процесс ажиллагаатай байна.

#### 4. БНХАУ-ЫН “УРЬДЧИЛСАН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ”-ИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ТАЛААР

БНХАУ-ын ИПХ-ийн дагуу нэхэмжлэгч нэхэмжлэл гаргасны дараа дараах ажиллагаа явагддаг.<sup>39</sup>

- Нэхэмжлэлийг хүлээн авч хэрэг үүсгэх;
- Шүүх хуралдааны өмнөх бэлтгэл;
- Шүүх хуралдаан явуулах.

Урьдчилсан хэлэлцүүлэг явуулахтай холбоотойгоор БНХАУ-ын хэрэг үүсгэх бүрэлдэхүүн (立案庭) болон шүүх хуралдааны өмнөх уулзалт (庭前会议) гэсэн хоёр ойлголтыг тайлбарлах нь зүйтэй гэж үзлээ.

#### **БНХАУ-ын хэрэг үүсгэх бүрэлдэхүүн болон шүүх хуралдаанд бэлтгэх<sup>40</sup>:**

БНХАУ-ын иргэний процесст “Хэрэг үүсгэх” (立案) гэсэн ойлголтыг “хэрэг үүсгэх бүрэлдэхүүний үйл ажиллагаа, чиг үүрэг” гэсэн утгаар ойлгодог. Хэрэг үүсгэх бүрэлдэхүүн нь шүүхийн доторх нэг төрлийн механизм, зохион байгуулалт бөгөөд 1980-1990 оны дунд үеэс “шүүхээр хэлэлцүүлэх хэргийг ялгах” гэсэн шинэчлэлийн бодлогын хүрээнд “хэрэг үүсгэх бүрэлдэхүүн” нь шат бүрийн шүүхүүдийн ерөнхий нэгж болсон. Энэ бүрэлдэхүүний хариуцдаг үндсэн үйл ажиллагаа, чиг үүрэг нь нэхэмжлэгч нэхэмжлэл гаргасны дараа тухайн нэхэмжлэлийг хэлбэр болон хуулийн шаардлагын хувьд шалгаж хүлээж авах эсэхийг шийдвэрлэдэг.

Тус бүрэлдэхүүний үйл ажиллагаа нь өргөжиж нэхэмжлэлийг хүлээн авахаас өмнө маргааныг тогтоох, хүлээн авсны дараа шүүх хуралдаанд бэлтгэх зэрэг анхан шатны шүүхийн процессын эхэн үед олон төрлийн үүргийг гүйцэтгэдэг болсон. Өөрөөр хэлбэл нэхэмжлэлийг шалгаж хэргийг хүлээн авах эсэхийг шийдвэрлэх чиг үүргээс (шүүхэд ирж буй хэргийг шүүлтүүрдэх чиг үүрэг) гадна маргааныг шийдвэрлэх арга зам буюу “тухайн маргааныг хэрхэн хурдан шийдвэрлэх вэ?” гэдэгт төвлөрсөн чиг үүргүүдийг хэрэгжүүлдэг байна. Мөн нэхэмжлэл болон хариу тайлбарыг хүргүүлэх, үүргийн биелэлтийг баталгаажуулах, хэргийн харьяаллын талаар гаргасан эсэргүүцэл, нотлох баримтыг гаргаж өгөх, үнэлгээ хийлгэх ажлыг зохион байгуулах зэрэг шүүх хуралдаанд бэлтгэх чиг үүрэг, хэргийн мэдээлэл оруулах, хэргийн болон шүүх хурлын удирдлагын чиг үүргийг хэрэгжүүлдэг.

ИПХ-ийн 133 дугаар зүйлд<sup>41</sup> зааснаар Ардын шүүх хүлээн авсан хэргийн хувьд нөхцөл байдлаар нь ялгаж шийдвэрлэх арга замыг сонгохоор хуульчилсан ба тус зүйлийн 2 дахь хэсэгт “шүүх хуралдаанаас өмнө эвлэрүүлэн зуучлах боломжтой тохиолдолд цаг алдалгүй эвлэрүүлэн зуучлах замаар маргааныг шийдвэрлэх”; тус зүйлийн 4 дэх хэсэгт “шүүх хуралдаан явуулах шаардлагатай тохиолдолд хэргийн оролцогчдод нотлох баримтыг

<sup>39</sup> 中华人民共和国民事诉讼法第十二章第一到第三节 · [http://www.npc.gov.cn/zgrdw/npc/xinwen/2017-06/29/content\\_2024892.htm](http://www.npc.gov.cn/zgrdw/npc/xinwen/2017-06/29/content_2024892.htm), (Сүүлд үзсэн: 2022.11.09).

<sup>40</sup> 王亚新, 陈杭平, 刘君博著“中国民事诉讼法重点讲义”(第二版)第270页

<sup>41</sup> 中华人民共和国民事诉讼法第一百三十三条 · [http://www.npc.gov.cn/zgrdw/npc/xinwen/2017-06/29/content\\_2024892.htm](http://www.npc.gov.cn/zgrdw/npc/xinwen/2017-06/29/content_2024892.htm), (Сүүлд үзсэн: 2022.11.09).



танилцуулах гэх мэт аргаар дамжуулан маргааны гол асуудлыг тодорхой болгоно” гэж заасан.

Эдгээр зохицуулалтуудын ач холбогдол нь ердийн журмаар шийдвэрлэх зарим хэрэгт хэргийн тоо олон байдаг, хэргийн нөхцөл байдал төвөгтэй, нотлох баримт тал талд байгаа, нотлох баримтыг аль болох бүрэн цуглуулж, танилцуулах ажлыг эхний шатанд хөнгөвчлөх боломжтой, үүнд үндэслэн хэргийг тодруулах боломжтой, талуудын маргааны гол асуудлыг цэгцлэх, албан ёсоор шүүх хурал хийсний дараа хэргийн үйл баримтын агуулга илүү цэгцтэй болж бодитойгоор шүүх хурал явагдах явдалд хүргэх юм. Нөгөөтээгүүр, хэрэв бүрэн гүйцэд сайн бэлтгэл хийгээгүйгээр шүүх хуралдаан явуулбал, шүүх хуралдааны хэмнэлийг удаашруулж, цаг хугацаа, их хөдөлмөр шаардах боловч үр дүнд хүрэхгүй, эсвэл шүүх хурлыг дахин давтаж хийх, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа үр ашиггүй, хэрэг маргааныг ноцтойгоор удаашруулахад хүргэж болзошгүй юм.

### **Шүүх хуралдааны өмнөх уулзалт (庭前会议)<sup>42</sup>:**

“Нотлох баримтыг эрт гаргаж өгөх”, “Мэдээллийг бүрэн бэлтгэх, маргааны гол асуудлыг цэгцлэх”, “Нэхэмжлэлийг үр дүнтэй болгох” зэрэг бэлтгэл ажиллагаанууд нь хэргийн оролцогчдод эвлэрэх боломжийг олгож шүүхэд эвлэрүүлэн зуучлах арга замыг хэрэглэн маргааныг эрт шийдвэрлэх боломж олгодог. Шүүгч иргэний хэргийг үүсгэхээс өмнө шүүхэд хандан гаргасан нэхэмжлэлүүд түүнийг шийдвэрлэх шүүх бүрэлдэхүүнтэй харьцуулахад их байдагтай холбоотойгоор юуны түрүүнд талуудыг эвлэрүүлэх арга хэмжээг авахыг зорьдог. Шүүх нэхэмжлэлийг хүлээн авсны дараа хэргийн нөгөө талтай холбогдож хүлээн зөвшөөрч буйг нь асууж зөвшөөрч байвал эвлэрүүлэн зуучлах уулзалтыг зохион байгуулдаг. Түүнчлэн бага хэмжээний мөнгөн дүнтэй хэрэг, талуудын хооронд үүссэн жижиг маргаан болон тухайн хэргийн энгийн байдлыг харгалзан хялбаршуулсан журмаар шийдвэрлэдэг байна.

**Шүүх хуралдаанаас өмнө хялбар шуурхай аргаар хэргийн оролцогчдыг цуглуулан шүүх хуралдааны бэлтгэл ажиллагаануудын нэг эсхүл хэд хэдийг хангахын тулд албан бус уулзалтыг зохион байгуулж болдог. Шүүх хуралдаан явуулахаас өмнө хийх нэг эсхүл хэд хэдэн удаагийн уулзалтыг “шүүх хуралдааны өмнөх уулзалт” гэж нэрлэдэг.** ИПХ-ийн тайлбарын 224 дүгээр зүйлд “шүүх хариуцагчийн хариу тайлбар ирүүлэх хугацаа дууссаны дараа нотлох баримт солилцох ажлыг зохион байгуулах, шүүх хуралдааны өмнөх уулзалтыг зохион байгуулах зэрэг арга хэрэгслээр шүүх хуралдааны бэлтгэлийг хангаж болно” гэж заасан.

Практикт нотлох баримтыг цуглуулах ажлыг шүүх бүрэлдэхүүний гишүүн шүүгч, шүүгчийн туслах, нарийн бичиг нар удирдан явуулдаг. Нотлох баримтыг цуглуулах, солилцох ажиллагаа нь доорх 2 төрөлтэй:

1. Хэргийн оролцогчид тогтоосон хугацаанд шүүхэд өөрсдийн нотлох баримтыг гаргаж өгч, нөгөө талын гаргасан нотлох баримттай танилцана. Ихэвчлэн баримт бичгийн төрлийн нотлох баримтууд болон хуулбаруудад хэрэглэгдэнэ.
2. Хэргийн оролцогчид нүүр нүүрээ харж байгаад тус тусын нотлох баримтуудаа зэрэг гарган өгч нотлох баримт тус бүрд өөрсдийн үзэл бодлоо илэрхийлэх эсхүл нотлох баримтад урьдчилсан шалгалт хийх боломжтой. Баримт бичгийн нотлох баримтаас бусад нотлох баримт буюу гэрчийн мэдүүлгийг газар дээр нь авах, нотлох баримтыг тэмдэглэн авах, хэргийн явцтай танилцах зэрэг байж болно.

<sup>42</sup>王亚新, 陈杭平, 刘君博著“中国民事诉讼法重点讲义”(第二版)第280页



Эдгээр нь уулзалтын хэлбэрээр явагдана. Энэ төрлийн уулзалт нь ганцхан нотлох баримт гаргаж өгөхтэй холбогдолтой биш бөгөөд **талууд өөрт байгаа нотлох баримтуудаа шүүхэд гаргаж өгөх, нотлох баримтуудыг солилцох, газар дээр нь байгаа нотлох баримтуудтай танилцах, нөгөө талын гаргаж өгч буй нотлох баримтуудад ямар үзэл бодолтой байгаагаа илэрхийлэх боломжтой ба шүүх бүрэлдэхүүний гишүүн хэргийн үйл баримтаас маргаангүй хэсгийг хасаж үлдэж буй маргаантай асуудлыг тодорхой болгох талаар хэргийн оролцогчдыг чиглүүлэх зэрэг байж болно.**

Энэ шатанд хэргийн оролцогч 2 тал өөрт үлдээх болон гаргаж өгөх шаардлагатай нотлох баримтуудын талаар тодорхой ойлголттой болохын зэрэгцээ өөрийн болон эсрэг талынхаа давуу болон сул тал, нөхцөл байдлын талаар ерөнхий ойлголттой болно. Шүүх бүрэлдэхүүний гишүүн яг энэ үед талуудад нөхцөл байдлыг ойлгуулж эвлэрүүлэн зуучлуулах замаар маргааныг шийдвэрлүүлэхээр чиглүүлэхэд амжилттай болох магадлал өндөр байдаг. Өөрөөр хэлбэл, нотлох баримт гаргаж өгөх солилцох, маргааныг цэгцлэх болон шүүх хуралдааны өмнө эвлэрүүлэн зуучлах зэрэг үйл ажиллагаа, чиг үүргийг бүгдийг нь нэгтгэж нэг “шүүх хуралдааны өмнөх уулзалт”-аар шийдэх эсхүл тус тусад нь салгаж хэд хэдэн ижил төрлийн уулзалтууд хийж болно.

2015 оны “ИПХ-ийн тайлбар”<sup>43</sup>-ын 225 дугаар зүйлд шүүх хуралдааны өмнөх уулзалтын агуулгыг дараах байдлаар зохицуулсан:

1. Нэхэмжлэгчийн нэхэмжлэлийн шаардлага, хариуцагчийн хариу тайлбарыг тодорхой болгох;
2. Хэргийн оролцогчдын нэхэмжлэлийн шаардлагаа нэмэгдүүлэх, өөрчлөх хүсэлт болон сөрөг нэхэмжлэл, гуравдагч этгээдийн тус хэрэгтэй холбогдуулж гаргасан нэхэмжлэлийг шалгаж шийдвэрлэх;
3. Хэргийн оролцогчдын гаргасан хүсэлт дээр тулгуурлан нотлох баримт цуглуулахаар шийдвэрлэх, үнэлгээ тогтоох этгээдийг томилох, талуудаас нотлох баримт гаргуулах, үзлэг хийх, нотлох баримтыг хамгаалах арга хэмжээ авах;
4. Нотлох баримтыг гаргуулах, солилцохыг зохион байгуулах;
5. Маргааны гол зүйлийг нэгтгэн дүгнэх;
6. Эвлэрүүлэн зуучлалыг зохион байгуулах.

Ийм төрлийн бэлтгэх үйл ажиллагаа явуулснаар шүүхийн өмнөх эвлэрүүлэн зуучлал амжилт олоогүй, нотлох баримтууд бүрэн цугларсан, хэргийн оролцогчдын хоорондох маргааны зүйл тодорхой болсон зэрэг урьдчилсан нөхцөлүүд тодорхой болж шүүх хуралдаан илүү бүрэн гүйцэд, үр дүнтэй явагддаг.

#### ***Иргэний хэргийн шүүх хуралдааны өмнөх уулзалтын үйл явц<sup>44</sup>:***

##### **1. Хүсэлтийг шийдвэрлэх**

Шүүх хуралдааны өмнөх уулзалт нь хэргийн төвөгтэй байдал, талуудын маргалдаж буй зүйл тодорхой бус байх нөхцөл байдалд тулгуурлан үүсдэг шүүхээс зохион байгуулдаг үйл ажиллагаа юм. Иймд маргааны агуулгыг илүү тодорхой болгох зорилгоор шүүх

<sup>43</sup> 2015 年《民事诉讼法解释》第 225 条

<sup>44</sup> <https://www.66law.cn/laws/1724255.aspx>, (Сүүлд үзсэн: 2022.11.04).



талуудын хүсэлт, тайлбарыг шийдвэрлэх ажлыг нарийн бичгийн даргаар дамжуулан зохион байгуулдаг.

2. Шинэ нөхцөл байдлыг асууж тодруулах

Хэргийн оролцогчид шүүх хуралдаан эхлэхээс өмнө өөрсдийн нотлох баримт, тайлбараа хадгалж хамгаалах явдал элбэг бөгөөд нөхцөл байдлын хувьд өөрчлөлт гарах, талуудад ямар нэгэн эсэргүүцэл байхыг үгүйсгэх аргагүй тул албан ёсны шүүх хуралдааныг илүү үр дүнтэй явуулах зорилгоор шүүх ихэнхдээ шүүх хуралдааны өмнөх уулзалтаар хэргийн оролцогчид нэхэмжлэлийн шаардлагаа нэмэгдүүлэх, өөрчлөх эсхүл сөрөг нэхэмжлэл гаргах, гуравдагч этгээд нэхэмжлэл гаргах зэрэг нөхцөл байдлууд байгаа эсэхийг тодорхойлж ойлгохыг зорьдог.

3. Арга хэмжээ авах

Хэрэв шүүх хуралдааны явцад хэргийн оролцогчид нотлох баримтыг хамгаалах, үнэлгээ хийлгэх, мөрдөн шалгалт хийх, нотлох баримт цуглуулах зэрэг хүсэлт гаргавал шүүх хуралдааны үр дүнтэй байдалд нөлөөлж болзошгүй тул шүүх хуралдааны энэ төрлийн нөхцөл байдлыг багасгахын тулд шүүх хуралдааны өмнөх хурал хийж хэргийн оролцогчдоос ийм төрлийн хүсэлт гаргах эсэхийг асууж тодруулан эрт зохион байгуулалт хийдэг.

4. Нотлох баримтыг гаргаж өгөх, солилцох

Төвөгтэй хэргийн хувьд нотлох баримтууд нь илүү олон байдаг тул шүүх хуралдааны явцад талууд нотлох баримт гаргаж өгөх, шинжлэн судлуулах нь шүүх хуралдаан явагдах хугацаанд нөлөөлдөг тул ийм төрлийн хэргийн хувьд ихэнхдээ шүүх хуралдааны өмнөх хурлын үед хэргийн оролцогчдын дунд нотлох баримтыг гаргаж өгөх, солилцох ажлыг зохион байгуулдаг.

5. Гол асуудлыг нэгтгэн дүгнэх

Шүүх хуралдааны өмнөх хурлын үед нарийн бичгийн дарга болон шүүгчээр дамжуулан хэргийн оролцогчид нэхэмжлэл болон тухайн хэргийн үндсэн нөхцөл байдлыг ойлгосны дараа маргааны зүйлийн талаар ерөнхий ойлголттой болж, хэргийн үйл баримт тодорхой болж шүүгчид хэргийг шийдвэрлэхэд давуу тал бий болдог.

6. Шүүхийн эвлэрүүлэн зуучлал болон талууд эвлэрэх

Хэрэв нарийн бичгийн дарга эсхүл шүүгч хэргийн оролцогчдын нөхцөл байдлыг шалган тогтоосны дараа хэргийн оролцогчдын хооронд эвлэрэх боломж байвал эвлэрүүлэн зуучлах ажлыг эрт зохион байгуулж хэргийг хялбар байдлаар шийдвэрлэж болно.

БНХАУ-ын хувьд юун түрүүнд нэхэмжлэл гаргасны дараа хэргийг хүлээн авахаас өмнө тухайн маргааны агуулгыг тогтоож хэлбэрийн болон хууль зүйн шаардлага хангасан эсэхийг шалган хэрэг хүлээн авах эсэхийг шийдвэрлэдэг “хэрэг үүсгэх бүрэлдэхүүн” байдаг. Үүний дараа хэргийг хянан хэлэлцэх явцад урьдчилан хэлэлцүүлэг буюу “шүүх хуралдааны өмнөх уулзалт”-аар нэхэмжлэлийн шаардлага, хариуцагчийн хариу тайлбарыг тодорхой болгох, хэргийн оролцогчдын нэхэмжлэлийн шаардлагаа нэмэгдүүлэх, өөрчлөх хүсэлт болон сөрөг нэхэмжлэл, гуравдагч этгээдийн тус хэрэгтэй холбогдуулж гаргасан нэхэмжлэлийг шалгаж шийдвэрлэх, хэргийн оролцогчдын гаргасан хүсэлт дээр тулгуурлан нотлох баримт цуглуулахаар шийдвэрлэх, үнэлгээ тогтоох этгээдийг томилох, талуудаас нотлох баримт гаргуулах, үзлэг хийх, нотлох баримтыг хамгаалах арга хэмжээ авах, нотлох баримтыг гаргуулах, солилцохыг зохион байгуулах, маргааны гол зүйлийг нэгтгэн дүгнэх, эвлэрүүлэн зуучлалыг зохион байгуулах зэргийг шийдвэрлэдэг байна. БНХАУ-ын “шүүх хуралдааны өмнөх уулзалт” нь шүүх хуралдааныг чирэгдэлгүй илүү хялбар, шуурхай үр дүнтэй явуулахад чиглэдэг бөгөөд талуудыг эвлэрүүлэхэд чухал нөлөө үзүүлдэг.



## 5. ОХУ-ЫН ШҮҮХИЙН УРЬДЧИЛСАН ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН ТАЛААР

Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг нь арбитрын болон иргэний журмаар маргааныг шүүхээр хэлэлцүүлэхээр бэлтгэх эцсийн шат юм. Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгээр хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлүүлэхээр шилжүүлж болно. Үүнийг 2017 оны 04-р сарын 18-ны өдрийн тогтоолын 15-р зүйлд заасны дагуу ОХУ-ын Дээд шүүх шүүх хуралдаанд бэлтгэх явцад энэ талаар тогтоосон<sup>45</sup>.

Арбитрын журмаар хянан шийдвэрлэх хэрэг маргааны хувьд урьдчилсан хэлэлцүүлгийн үе шаттай байдаг. Тухайлбал, ОХУ-ын АХХШТХ-ийн 136 дугаар зүйлийн 2-т заасны дагуу<sup>46</sup>:

- Шүүгч маргааны талуудын өргөдлийн дагуу шийдвэр гаргах;
- Нотлох баримтыг үнэлэх;
- Эвлэрүүлэн зуучлах журмыг хэрэглэхийг дэмждэг байна.

ОХУ-ын Дээд шүүх урьдчилсан хэлэлцүүлгийг бүхэл бүтэн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зайлшгүй нэг хэсэг гэж үздэггүй. Тиймээс хурлын тэргүүлэгчид давж заалдах гомдлыг шилжүүлэхээс татгалзсан бөгөөд маргааны үйл явц дахь шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг хийгээгүй ба ОХУ-ын АХХШТХ-ийн 136 дугаар зүйлийг зөрчсөн гэж үзжээ.

ОХУ-ын АХХШТХ-ийн 291.11 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг (2019 оны 11-р сарын 6-ны өдрийн № 303-ES19- 19398 тогтоол)-ийн дагуу өргөдөл гаргагчийн гомдлыг хариуцагч этгээдэд хүлээлгэх, доод шатны шүүхийн актыг хүчингүй болгох үндэслэл тогтоогдоогүй гэж шүүх үзсэн байна<sup>47</sup>.

|  |   |
|--|---|
| <p>ОХУ-д “урьдчилсан хэлэлцүүлэг” гэдгийг “предварительные слушание” гэж нэрлэдэг бөгөөд ОХУ-ын <i>ИХШХШТХ-ийн 152 дугаар зүйлд “Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг”-ийг “Статья 152. Предварительное судебное заседание”</i><sup>48</sup> гэх гарчигтайгаар зохицуулсан.</p>  | <p>Мөн 2002 оны 07-р сарын 24-ний өдрийн <i>№95-ФЗ</i> дугаартай ОХУ-ын “АХХШТХ”/-л Арбитрын шүүх нь эдийн засгийн маргаан, аж ахуй эрхлэх болон эдийн засгийн бусад үйл ажиллагаатай холбоотой бусад хэргийг хянан хэлэлцдэг бөгөөд шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн талаар мөн адил зохицуулж өгсөн байна<sup>49</sup>.</p> |
| <p><b>1. Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийг явуулах зорилго нь хэргийг шүүх хуралдаанд бэлтгэх явцад зохигчдын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг нэгтгэх, хэргийг зөв хянан шийдвэрлэхэд чухал ач холбогдолтой нөхцөл байдлыг тогтоох, хэрэгт авагдсан нотлох баримтын хангалттай эсэхийг тогтоох, шүүхэд хандах, нэхэмжлэл гаргах эцсийн хугацааг</b></p> | <p><b>Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгээр хэргийг ганц шүүгч хэлэлцдэг</b> ба хэлэлцүүлэг болох цаг, газрын талаар талууд болон бусад сонирхогч этгээдэд мэдэгдэнэ. Эдгээр оролцогч нар энэ хуулийн 153.1-т заасны дагуу дүрс бичлэгийн хэлэлцүүлгийн холболт систем, эсхүл 153.2-т заасны дагуу веб</p>                         |

<sup>45</sup> [https://vip.1jur.ru/?utm\\_source=arbitr-praktika.ru&utm\\_medium=refer&utm\\_campaign=refer\\_arbitr-praktika.ru\\_content\\_link\\_native\\_middle&utm\\_term=2482&utm\\_content=art#/document/96/456058584/](https://vip.1jur.ru/?utm_source=arbitr-praktika.ru&utm_medium=refer&utm_campaign=refer_arbitr-praktika.ru_content_link_native_middle&utm_term=2482&utm_content=art#/document/96/456058584/) (Сүүлд үзсэн: 2022.11.04).

<sup>46</sup> [https://vip.1jur.ru/?utm\\_source=arbitr-praktika.ru&utm\\_medium=refer&utm\\_campaign=refer\\_arbitr-praktika.ru\\_content\\_link\\_native\\_middle&utm\\_term=2482&utm\\_content=art#/document/99/901821334/ZA00M462LP/](https://vip.1jur.ru/?utm_source=arbitr-praktika.ru&utm_medium=refer&utm_campaign=refer_arbitr-praktika.ru_content_link_native_middle&utm_term=2482&utm_content=art#/document/99/901821334/ZA00M462LP/), (Сүүлд үзсэн: 2022.11.04).

<sup>47</sup> [https://vip.1jur.ru/?utm\\_source=arbitr-praktika.ru&utm\\_medium=refer&utm\\_campaign=refer\\_arbitr-praktika.ru\\_content\\_link\\_native\\_middle&utm\\_term=2482&utm\\_content=art#/document/96/563689735/](https://vip.1jur.ru/?utm_source=arbitr-praktika.ru&utm_medium=refer&utm_campaign=refer_arbitr-praktika.ru_content_link_native_middle&utm_term=2482&utm_content=art#/document/96/563689735/) (Сүүлд үзсэн: 2022.11.07).

<sup>48</sup> [http://www.consultant.ru/document/cons\\_doc\\_LAW\\_39570/3989963941583aacac6a09ddd3749642813e9a0d/](http://www.consultant.ru/document/cons_doc_LAW_39570/3989963941583aacac6a09ddd3749642813e9a0d/), (Сүүлд үзсэн: 2022.11.07).

<sup>49</sup> [https://vip.1jur.ru/?utm\\_source=arbitr-praktika.ru&utm\\_medium=refer&utm\\_campaign=refer\\_arbitr-praktika.ru\\_content\\_link\\_native\\_middle&utm\\_term=2482&utm\\_content=art#/document/99/901821334/ZA00M462LP/](https://vip.1jur.ru/?utm_source=arbitr-praktika.ru&utm_medium=refer&utm_campaign=refer_arbitr-praktika.ru_content_link_native_middle&utm_term=2482&utm_content=art#/document/99/901821334/ZA00M462LP/), (Сүүлд үзсэн: 2022.11.07).



**хэтрүүлсэн нотлох баримтуудыг шалгахад оршино (152 дугаар зүйлийн 1-т).**

**Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийг нэг шүүгч явуулна.** Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн тов болон болох газрын тухай талуудад мэдэгдэнэ.

**Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн үеэр оролцогчид нотлох баримт гаргах, мэтгэлцэх, өргөдөл гаргах эрхтэй.** Мөн талуудыг дүрс бичлэгийн хэлэлцүүлгийн холболт систем эсхүл веб хурлын системийг ашиглан шүүх хуралдааны урьдчилсан хэлэлцүүлэгт оролцохыг зөвшөөрнө. Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэгт шүүгч маргааныг шийдвэрлэх тохиолдолд талуудын санал бодлыг сонсох, улмаар эвлэрүүлэн зуучлах үйл ажиллагааг явуулж болно **(152 дугаар зүйлийн 2-т).**

Шүүгч шийдвэрлэхэд **хүндрэлтэй тохиолдлын хувьд** талуудын саналыг харгалзан шүүх хуралдааны урьдчилсан хэлэлцүүлгийг энэ хуулиар тогтоосон хэрэг хянан шийдвэрлэх хугацаанаас хэтрүүлэн тогтоож болно **(152 дугаар зүйлийн 3-т).**

Энэ хуулийн 215 дугаар зүйл, 216 дугаар зүйл, 220 дугаар зүйл, болон 222 дугаар зүйлийн 2-оос 6 дах хэсэгт заасан нөхцөл байдлууд үүссэн бол шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэгт хянан шийдвэрлэх үйл ажиллагааг түдгэлзүүлэх, эсхүл дуусгавар болгож, талуудын хүсэлтийг хянан авч хэлэлцэхгүйгээр хэвээр үлдээж болно **(152 дугаар зүйлийн 4-т).**

Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгээр шүүхээс хүлээн авсан хэргийг ерөнхий харьяаллын өөр шүүх, арбитрын шүүхэд шилжүүлэх тухай асуудлыг хянан шийдвэрлэж болно **(152 дугаар зүйлийн 4 дүгээр зүйлийн 1-т).**

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэх, дуусгавар болгох, эсхүл өргөдлийг хянан авч хэлэлцэхгүйгээр орхих тухай шүүгч захирамж гаргана. Энэхүү шүүгчийн захирамжид гомдол гаргах эрхтэй **(152 дугаар зүйлийн 5-т).**

Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэгт нэхэмжлэгч өөрийн эрхээ хамгаалах хөөн хэлэлцэх хугацаа, шүүхэд өргөдөл гаргах холбооны хуулиар тогтоосон хугацааг байхгүй байгаатай холбогдуулан хариуцагчийн эсэргүүцлийг хянан авч үзэж болно.

Шүүгч хөөн хэлэлцэх хугацаа буюу шүүхэд хандах хугацааг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хэтрүүлсэн нь тогтоогдвол хэрэгт авагдсан бусад нөхцөл байдлыг авч үзэлгүйгээр нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгоно. Уг шүүхийн шийдвэрт давж заалдах журмаар гомдол гаргаж болно **(152 дугаар зүйлийн 6-т).**

Эцэг эхийн хүсэлтээр хүүхдийн маргааныг шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгээр хэлэлцэхдээ заавал асран хамгаалах, асран хамгаалах байгууллагын оролцоотойгоор шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болох хүртэлх хугацаанд шүүх хүүхдийн оршин суугаа газар эсхүл эцэг, эх байх эрхийг хэрэгжүүлэх журмыг тогтоох эрхтэй. Эдгээр асуудлаар асран хамгаалах, асран хамгаалах байгууллагын хүлээн зөвшөөрсөн дүгнэлт гарсан тохиолдолд хүүхдийн саналыг заавал харгалзан үзсэний үндсэн дээр шийдвэр гаргадаг. Холбогдох шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болохоос өмнө тухайн хугацаанд хүүхдийн оршин суугаа газар өөрчлөгдсөн нь хүүхдийн ашиг сонирхолд харшилж байгааг илтгэсэн нөхцөл байдал үүссэн бол шүүх хүүхдийн оршин суугаа газар, хүүхдийн одоогийн бодит

хурлын системийг ашиглан шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэгт оролцох эрхтэй.

**Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн талаар зохих ёсоор мэдэгдсэн нэхэмжлэгч (эсхүл) хариуцагч, мөн хэрэгт оролцож болох бусад сонирхогч хүмүүс ирээгүй тохиолдолд хэлэлцүүлгийг тэдний эзгүйд явуулж болно (АХХШтХ-ийн 136-р зүйлийн 1-т).**

Арбитрын шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэгт **(АХХШтХ-ийн 136-р зүйлийн 2-т):**

1. Талуудын гаргасан өргөдлийг шийдвэрлэх.
2. Шүүхэд ирүүлсэн нотлох баримтын хангалттай эсэхийг тодорхойлж, хэрэгт ямар нотлох баримт байгаа талаар талуудад мэдээлэх
  - 2.1. Маргааныг шийдвэрлэх боломжийн тухайд талуудын саналыг авах, талуудыг эвлэрүүлэн зуучлах журмын дагуу хэргээ шийдвэрлүүлэхийг уриалах, талууд шүүхийн эвлэрүүлэн зуучлагчид өргөдөл гаргахад шүүх энэ хуульд заасан журмын дагуу талуудын сонгосон эвлэрүүлэн зуучлагчийг оролцуулахыг зөвшөөрөх
3. Хэргийг шүүх хуралдаанд бэлтгэхдээ шийдвэрлэх асуудлыг хэлэлцэх, энэ хуульд заасан бусад хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг гүйцэтгэх зэрэг ажиллагаа хамаарна.

**Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэгт талууд хуралдаанаас гарсан бүх асуудлаар нотлох баримт гаргаж өгөх, хүсэлт гаргах, өөрсдийн үндэслэлийн талаар байр сууриа илэрхийлэх эрхтэй (АХХШтХ-ийн 136-р зүйлийн 3-т).**

**Шүүх хэргийн оролцогч нарын хүсэлтээр нэмэлтээр нотлох баримт гаргуулах шаардлагатай тохиолдолд шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийг таваас илүүгүй хоногоор хойшлуулах эрхтэй (АХХШтХ-ийн 136-р зүйлийн 4-т).**

**Арбитрын шүүх урьдчилсан хэлэлцүүлгээр орж буй бүх асуудлыг хэлэлцэж дууссаны дараа хэргийн оролцогч, гуравдагч этгээдийн саналыг харгалзан хэргийг шүүх хуралдаанд оруулахад бэлэн эсэхийг шийдвэрлэнэ (АХХШтХ-ийн 136-р зүйлийн 5-т).**



оршин суугаа газрыг тогтоолгох тухай шүүхийн хүчин төгөлдөр шийдвэр гарах хүртэлх хугацаанд хүүхдийн оршин суугаа газрыг тодорхойлно (**152 дугаар зүйлийн 6 дугаар зүйлийн 1-т**).

Мөн хуулийн 417.7 дугаар зүйлд “**Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн онцлог, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг дуусгавар болгох**”<sup>50</sup> талаар зохицуулж өгсөн байна. Үүнд:

Энэ хуулийн 152 дугаар зүйлд заасны дагуу шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгээр хянан хэлэлцэж буй маргаантай холбогдуулан талуудын оролцоотойгоор гадаад улсын төлөөлөгч шүүхийн дархан эрхтэй байна. (**417.7 дугаар зүйлийн 1-т**)

Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг болох цаг болон газрын талаар зохих ёсоор мэдэгдсэн гадаад улсын төлөөлөгчид ирээгүй тохиолдолд шүүх хэрэгт байгаа нотлох баримтын хүрээнд хэргийг шийдвэрлэнэ (**417.7 дугаар зүйлийн 2-т**).

Хэрэгт авагдсан материалууд нь шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн үеэр шүүгчид, шүүхээр хэлэлцэж буй маргааны талаар гадаад улс шүүхэд халдашгүй дархан эрхтэй гэсэн дүгнэлтийг гаргах боломжийг олгохгүй тохиолдолд энэ асуудлыг шүүх хуралдааны явцад шийдвэрлэнэ. (**417.7 дугаар зүйлийн 3-т**).

Шүүхээс тогтоосон нөхцөл байдал, нэхэмжлэлийн шаардлагыг хангах арга хэмжээний хувьд болон шүүхийн шийдвэрийг биелүүлэхтэй холбогдуулан гадаад улс халдашгүй дархан эрхтэй гэсэн шүүхийн дүгнэлтийг хэргийг хянан хэлэлцсэн үр дүнд үндэслэн гаргасан шүүхийн шийдвэрт тусгагдсан байх ёстой (**417.7 дугаар зүйлийн 4-т**).

Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэгт эсхүл шүүх хуралдааны явцад гадаад улс шүүхийн дархан эрхтэй гэсэн дүгнэлтэд хүрсэн бол шүүх үүнтэй холбогдох хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг зогсооно (**417.7 дугаар зүйлийн 5-т**).

Дээрх хоёр төрлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хувьд урьдчилсан хэлэлцүүлгийг явуулахдаа хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ерөнхий журамд захирагдана. Нэмж дурдахад, ОХУ-ын Арбитрын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа болон ОХУ-ын Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн урьдчилсан хэлэлцүүлгийг ижил төстэй журмын дагуу явуулдаг. Жишээлбэл: Хоёр шатны шүүх хуралдаанд шүүгч хэргийг дангаар нь авч үздэг. (ОХУ-ын Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 152 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, ОХУ-ын Арбитрын хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 136 дугаар зүйлийн 1 дэх хэсэг).

Иргэний болон Арбитрын шүүх хуралдааны урьдчилсан хэлэлцүүлэгт талууд ижил эрхтэй байх /боломж/-ийн жагсаалттай байдаг. Шаардлагатай тохиолдолд видео хуралд оролцох систем ашиглах эрхтэй. Маргаанд оролцогчдод уг эрхийг ОХУ-ын ИХШХШТХ-ийн 152 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, АХХШТХ-ийн 136 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зохицуулсан. Нэхэмжлэгч, хариуцагч, түүнчлэн бусад шүүх хуралдааны оролцогч ирээгүй тохиолдолд хэргийг хэргийн оролцогчгүйгээр хянан хэлэлцэж болно. Гэхдээ хэргийн оролцогч нарт

<sup>50</sup>[http://www.consultant.ru/document/cons\\_doc\\_LAW\\_39570/89b7dcb43b59c9efbdf16914c2d7d01f22c3c879/](http://www.consultant.ru/document/cons_doc_LAW_39570/89b7dcb43b59c9efbdf16914c2d7d01f22c3c879/). (Сүүлд үзсэн: 2022.11.08).



шүүхийн урьдчилан хэлэлцүүлэг болох талаар мэдэгдэх ёстой. Оролцогч нарт энэ талаар зохих ёсоор мэдэгдсэн тухайгаа баримтад тэмдэглэнэ.

Арбитрын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд маргааны аль нэг талд нотлох баримт бүрдүүлэх хугацаа шаардлагатай тохиолдолд 5 хоног, түүнээс хэтрэхгүй хугацаагаар түдгэлзүүлж болно (ОХУ-ын Арбитрын хэрэг хянан шийдвэрлэх хуулийн 136 дугаар зүйлийн 4 дэх хэсэг).

Харин ИХШХШТХ-д зааснаар Арбитрын шүүхээс ялгаатай нь шийдвэрлэхэд нарийн төвөгтэй маргааны хувьд шүүгч талуудын саналыг харгалзан авч үзэж маргааныг хянан шийдвэрлэх тогтсон стандарт хугацаанаас гадна шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн хугацааг тогтоодог (ОХУ-ын Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 152 дугаар зүйлийн 3 дахь хэсэг).

Урьдчилсан хэлэлцүүлгийн үр дүнг үндэслэн шүүгч үндсэн шүүх хуралдааныг товлох тухай захирамж гаргадаг. Үүнээс гадна, урьдчилсан хэлэлцүүлгийг шүүгчийн шийдвэрээр нэн даруй үндсэн хэлэлцүүлэгт шилжүүлж болно (ОХУ-ын Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 153 дугаар зүйл, ОХУ-ын Арбитрын хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 137 дугаар зүйл). Гэхдээ шүүгч дангаараа хэргийг шийдвэрлэх ёстой бол үүний дагуу шийдвэрлэнэ. Харин маргааныг хамтад нь авч үзэх шаардлагатай тохиолдол гарч болох ч иймэрхүү өөрчлөлтийг хийдэггүй байна.

ОХУ-ын шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийг дүгнэн үзвэл, ИХШХШТХ болон АХШХШТХ-д тус тус зохицуулж өгсөн байна. Харин урьдчилсан хэлэлцүүлгийг явуулахад тус хоёр шүүх нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ерөнхий журмыг баримталдаг ба хуульд зааснаар урьдчилсан хэлэлцүүлгийг нэг шүүгч дангаар явуулах бөгөөд талуудыг дүрс бичлэгийн хэлэлцүүлгийн холболт систем эсхүл веб хурлын системийг ашиглан шүүх хуралдааны урьдчилсан хэлэлцүүлэгт оролцохыг өргөн хүрээнд зөвшөөрснөөрөө онцлог зохицуулалт болсон төдийгүй эрх зүйн зохицуулалтын хувьд ОХУ-ын ИХШХШТХ-д зохицуулсан “шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн онцлог, мөн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг дуусгавар болгох” зүйл, заалтад тусгагдсанаар гадаад улсын төлөөлөгч болон гадаад улс шүүхийн халдашгүй дархан эрхийн эрх зүйн үр дагаврыг зохицуулсан, мөн хүүхэдтэй холбоотой маргааныг хянан шийдвэрлэхийн тулд түүнд холбогдох хэргийг шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгээр оруулах талаар тус тус зохицуулсан нь өвөрмөц зохицуулалт болжээ.



## ДҮГНЭЛТ

Энэхүү судалгаанд шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийг иргэний хэрэг маргааныг хянан шийдвэрлэхэд ашиглах талаар гадаад улсын холбогдох хуулийн зохицуулалтыг судлаад дараах дүгнэлтийг хийлээ:

1. Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийг иргэний хэрэг маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд ашиглах нь маргааны агуулгыг тодорхойлох буюу нэхэмжлэлийн шаардлагыг тодорхой болгож, шүүх хуралдааныг үр ашигтай явуулах, цаг хугацаа болон эдийн засгийн үр өгөөжтэй байлгахад чиглэдэг байна. Ийнхүү урьдчилсан хэлэлцүүлэг явуулах нь шүүх хуралдааны үеэр хэргийг хойшлуулахгүй байж эцсийн байдлаар буюу нэг удаа шүүх хуралдааныг хийхэд чиглэдэг.
2. Зарим гадаад улсын ИПХ-ийг судлан, тухайн улсын хуульчилсан урьдчилсан хэлэлцүүлгийн ижил төстэй, ялгаатай талаас дурдвал:
  - ХБНГУ-ын ИПХ-д тусгагдсан урьдчилсан хэлэлцүүлэг нь шүүх хуралдааны бэлтгэл үе шатанд хамаарах ба нэхэмжлэл гаргасны дараагаар шүүх хуралдааны бэлтгэл үе шат эхэлж энэ шатанд урьдчилсан хэлэлцүүлэг (сонсгол) явагддаг. Мөн шаардлагатай тохиолдолд гэж үзвэл хэд хэдэн удаа энэхүү ажиллагаа явагддаг онцлогтой. Тухайн урьдчилсан хэлэлцүүлгийг аман болон бичгээр гэсэн хэлбэрээс сонгон явуулж болдог. Урьдчилсан хэлэлцүүлгээр шүүгч нь талуудад нэхэмжлэлийн зүйлээ тодруулах, маргааны зүйлийг тодорхойлоход зөвлөмж, чиглэмж өгөх, нотлох баримт бүрдүүлэх, цуглуулахад туслах, эрх бүхий байгууллагаас тодорхойлолт гаргуулахыг зөвлөх, талууд цуглуулсан нотлох баримтыг товчоор танилцуулах боломж олгох, гэрчийг асуух, шинжээч томилох, хариуцагчийн зүгээс хариу тайлбар гаргах хугацааг тогтоох, энэ талаар нэхэмжлэгчид мэдэгдэх зэрэг шүүх хуралдааны өмнөх шатанд хийгдэх үйл ажиллагааг хэрэгжүүлдэг. Ингэснээр шүүх хуралдааныг цаг алдалгүй хялбар явуулах боломж олгодог онцлогтой.
  - Япон Улсын хуульд тусгагдсан урьдчилсан хэлэлцүүлэг нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг үр дүнтэй шуурхай болгохын тулд маргааны зүйлийг тогтоох ажиллагаа гэсэн гурван төрөлтэй байна. Түүний гол зорилго нь маргааны зүйлийг тодорхой болгож, нотлох баримтыг бүрдүүлэх явдал юм. Хамгийн түгээмэл хэрэглэгддэг “бэлтгэл хэлэлцүүлэг” нь онолын хувьд маргааны зүйлийг тогтоох хамгийн үр дүнтэй ажиллагаа хэдий ч Япон Улсын тогтсон практикийн улмаас хангалттай үр дүнгээ өгч чаддаггүй байна.
  - БНСУ-ын урьдчилсан хэлэлцүүлэг нь бэлтгэл ажиллагаатай төсөөтэй байдлаар явагдах бөгөөд шүүх хуралдааныг түргэн шуурхай явуулахын тулд урьдчилсан хэлэлцүүлгээр нэхэмжлэлийн шаардлагыг тодорхой болгож, нотлох баримтыг талууд солилцох, шинээр нотлох баримт бүрдүүлэх, товч тайлбар гаргадаг байна.
  - БНХАУ-ын урьдчилсан хэлэлцүүлэг буюу “шүүх хуралдааны өмнөх уулзалт” нь шүүх хуралдааныг чирэгдэлгүй илүү хялбар, шуурхай үр дүнтэй явуулахад чиглэдэг бөгөөд талуудыг эвлэрүүлэхэд чухал нөлөө үзүүлдэг. Энэхүү урьдчилсан хэлэлцүүлэг буюу “шүүх хуралдааны өмнөх уулзалт”-аар маргааны агуулгыг тодорхой болгож нотлох баримтыг цуглуулах үнэлэх, хариуцагчийн хариу тайлбарыг тодорхой болгодог.
3. Иймд Монгол Улсын ИХШХШТХ-ийн шинэчилсэн найруулгад шүүх хуралдааны урьдчилсан хэлэлцүүлгийн зохицуулалтыг шинээр бий болгон хуульчлах



тохиолдолд бусад гадаад улсын эрх зүйн зохицуулалттай төстэй байдлаар тухайн урьдчилсан хэлэлцүүлгийн шатанд “эрх зүйн маргаантай харилцааг тогтоох, нэхэмжлэлийг зүйл, нэхэмжлэлийн шаардлагыг нарийвчлан тодорхойлох, нэхэмжлэл, хариу тайлбарын талаар тодруулах ажиллагаа хийх, талуудын гаргасан аливаа хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэх, тайлбар, нотлох баримт гаргах хугацаа, үеийг тодорхойлох, шинжээч томилох хүсэлтийг шийдвэрлэх” гэх мэт үйл ажиллагаа явуулах байдлаар зохицуулах нь оновчтой байж болохуйц байна гэж үзсэн болно.



## ЭХ СУРВАЛЖ

### Ном сурах бичиг:

1. 渡部美由紀他『民事訴訟法』111頁参照（日本評論社 2016年）。
2. 三木浩一他『民事訴訟法』184頁参照（有斐閣 第3版 2018年）。
3. 伊藤眞『民事訴訟法』292頁参照（有斐閣 第6版 2018年）。
4. 山本和彦「争点整理手続の過去、現在、未来」高田裕成他編『民事訴訟法の理論—高橋宏志先生古稀祝賀論文集』769頁、781頁参照（有斐閣 2018年）。
5. 最高裁判所事務総局編・裁判の迅速化に係る検証に関する報告書平成29年7月25頁表17参照（2017年）。

### Цахим ном, сурах бичиг:

1. Tae Hee Lee, Commercial litigation in Korea, 16, 2003.  
<https://www.worldservicesgroup.com/guides/Commercial%20Litigation%20in%20Korea.pdf>
2. Anna Nylund, The Structure of Civil proceedings – Convergence through the main hearing model?, 2018, p 15.
3. [https://uk.practicallaw.thomsonreuters.com/1-502-0728?transitionType=Default&contextData=\(sc.Default\)&firstPage=true#co\\_anchor\\_a778522](https://uk.practicallaw.thomsonreuters.com/1-502-0728?transitionType=Default&contextData=(sc.Default)&firstPage=true#co_anchor_a778522)
4. Hengeler Mueller, In Review: Court Procedure in Germany,  
<https://www.lexology.com/library/detail.aspx?g=58fc4314-c3e1-46d7-847e-b9194585c5c1>
5. <https://www.ojp.gov/ncjrs/virtual-library/abstracts/stuttgart-west-germany-model-access-justice-vol-2-1978-m>
6. John H. Langbeint, The German Advantage in Civil Procedure (The University of Chicago Law Review), 1985, p 824.  
[https://openyls.law.yale.edu/bitstream/handle/20.500.13051/4901/German\\_Advantage\\_in\\_Civil\\_Procedure\\_The.pdf;jsessionid=2407D6651C3A25695C5B500118990133?sequence=2](https://openyls.law.yale.edu/bitstream/handle/20.500.13051/4901/German_Advantage_in_Civil_Procedure_The.pdf;jsessionid=2407D6651C3A25695C5B500118990133?sequence=2)
7. Габлерын бизнесийн толь бичиг,  
<https://wirtschaftslexikon.gabler.de/definition/frueher-erster-termin-33307>
8. 中华人民共和国民事诉讼法第十二章第一到第三节 ·  
[http://www.npc.gov.cn/zgrdw/npc/xinwen/2017-06/29/content\\_2024892.htm](http://www.npc.gov.cn/zgrdw/npc/xinwen/2017-06/29/content_2024892.htm)
9. 王亚新, 陈杭平, 刘君博著“中国民事诉讼法重点讲义”（第二版）第270页
10. 中华人民共和国民事诉讼法第一百三十三条 ·  
[http://www.npc.gov.cn/zgrdw/npc/xinwen/2017-06/29/content\\_2024892.htm](http://www.npc.gov.cn/zgrdw/npc/xinwen/2017-06/29/content_2024892.htm)
11. 王亚新, 陈杭平, 刘君博著“中国民事诉讼法重点讲义”（第二版）第280  
<https://www.66law.cn/laws/1724255.aspx>
12. <https://vip.1jur.ru/>
13. <http://www.consultant.ru/>
14. <https://www.arbitr-praktika.ru/article/2482-predvaritelnoe-sudebnoe-zasedanie>